


МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
Орчин үеийн улс төрийн судалгааны төв



Авиалгалиг Дэмжигч болон  
Хориглогч Хүчин Зүйлс



UHLmann

СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР  
2007 он

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Авиалыг Дэмжигч болон  
Хориглогч Хүчин Зүйлс

УЛААНБААТАР

2007 он

ИН.МН  
СУДАЛГААНЫ САН

Энэхүү гарын авлагыг хэвлүүлэх ажлыг  
санхүүжүүлсэнд МУИС-ийн Азийн Судалгааны Төвд  
гүн талархлаа илэрхийлье.

Эхийг МУИС-ийн Орчин үеийн  
улс төрийн судалгааны  
төвд бэлтгэв.

МУИС-ийн Орчин үеийн  
улс төрийн судалгааны төв

### Авиалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Дизайнер Ц.Одбаясах  
Хэвлэлтэнд 2007 оны 04-р сарын 12  
Цаасны хэмжээ 60x90 1/16  
Хэвлэлийн хуудас 8  
Хэвлэсэн тоо 200 ширхэг



МУИС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Авиалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

### Төслийг гүйцэтгэгч байгууллага:

МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төв

### Төслийн багийн удирдагч:

Доктор Ж.Төртогтох

МУИС-ийн Орчин Үеийн Улс  
Төрийн Судалгааны Төвийн  
захирал, Улс төр судлалын  
тэнхмийн дэд профессор

### Төслийн багийн гишүүд:

Д.Оюунчимэг

Улс төр судлалын тэнхмийн ахлах  
багш, докторант

Ч.Өлзийсайхан

Улс төр судлалын тэнхмийн ахлах  
багш, докторант

С.Мөнхбат

Улс төр судлалын тэнхмийн багш,  
докторант

Д.Үндрах

Улс төр судлалын тэнхмийн багш,  
докторант

Энэхүү гарын авлагыг хэвлүүлэх ажлыг санхүүжүүлсэнд МУИС-  
ийн Азийн Судалгааны төвд гүн талархлаа илэрхийлье.

Эхийг МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвд  
бэлтгэв.

©Энэхүү ном нь МУИС-ийн Азийн Судалгааны төвийн санхүүжилтээр  
судлаачид, өргөн олон нийтэд зориулан хэвлэгэдсэн тул **ХУДАЛДАХ, АШИГ-  
ОЛОХ**-ыг хориглоно.

MINISTRY OF JUSTICE  
**СУДАЛГААНЫ САН**

## Агуулга

1. Хураангуйлсан үгийн товьёог	5
2. Хүснэгтийн товьёог	6
3. Зургийн товьёог	9
4. Оршил	11
5. Төслийн үндэслэл, зорилт, аргачлал, зохион байгуулалт	15
6. Авилгалын талаарх материалуудад хийсэн анализ	23
7. Тоон судалгааны анализ	40
8. Чанарын судалгааны анализ	51
9. Тоон болон чанарын судалгааны харьцуулалт, нэгдсэн анализ	66
10. Дүгнэлт ба зөвлөмжүүд	79
11. Хүснэгт ба Зураг	92
12. Ном зүй	108
13. Хавсралтууд	112

## Хураангуйлсан үгийн товьёог

АТГ	Авлигатай тэмцэх газар
АШСТО	Ардчиллыг Шинээр болон Сэргээн Тогтоосон Орнууд
БНОУХ	Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
МНХХ	Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НШУС	Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль
ОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ТББ	төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал

**Хүснэгтийн товьёог**

- Хүснэгт 1. Судалгааны түүврийн хэмжээ
- Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр
- Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, Монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсонтой санал нэгдэж байгаа эсэхээр
- Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, иргэдийн эрх, үүргээ ухамсарладаггүй байдал, хуулийн талаарх мэдээлэл хомс байдал нь авилгалыг өөгшүүлэгч нэг хүчин зүйл болж байгаа гэдэгтэй санал нийлж байгаа эсэхээр
- Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг өөгшүүлэгч хүчин зүйлүүдийн нэг нь териийн иргэдэд үйлчилэх үйлчилгээний олон шаталалт механизм түүнээс урган гарах хунд сурталт тогтолцоо гэдэгтэй санал нийлж байгаа эсэхээр
- Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалгаан, сонгосон үзүүлэлтүүдээр

**Хүснэгт 7a.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг таслан зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

**Хүснэгт 7b.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулж ажиллуулах гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

**Хүснэгт 7c.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалын талаар олон нийтийн дунд сургалт, сурталчилгааг сайн хийх гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

**Хүснэгт 7d.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, териийн албан хаагчдын ёс зүйн дүрэм баталж, чанд сахиулах гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

**Хүснэгт 7e.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал авдаг төдийгүй өгдөг этгээдэд хүлээлгэх шийтгэл бий болгох гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

**Хүснэгт 8.**

Судалгаанд хамрагдсан хүн амын хувь, авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийг тодорхойлсон байдлаар

СУДАЛГААНЫ САН

*Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс*

Хүснэгт 9.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийг тодорхойлсон байдлаар

*Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс*

**Зургийн товьёог**

Зураг 1.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалын хэрэг илрүүлэлт хангальгүй байгаад нөлөөлж буй шалтгаанаар

Зураг 2.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал, хээл хахуулийг баагасгахад ач холбогдолтой хүчин зүйлсийг үнэлсэн байдлаар

Зураг 3.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал авч, өгөх явдал тохиолдож байсан гэж нэрлэсэн байгууллагуудаар

Зураг 4.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг үнэлсэн байдлаар

Зураг 5.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг хориглоход нөлөөлөх эрх зүйн хүчин зүйлийг нэрлэсэн байдлаар

Зураг 6.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг хориглоход чиглэсэн улс төрийн чухал алхмуудаар

Зураг 7.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлийг нэрлэсэн байдлаар

Зураг 8.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувь, авилгалыг хориглоход нөлөөлөх эдийн засгийн алхмууд болон зан заншлын хүчин зүйлсийг нэрлэсэн байдлаар

## Оршил

Энэхүү гарын авлага номонд МУИС-ийн Азийн Судалгааны Төвийн санхүүжилтээр хийгдсэн “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийн судалгаа” төслийн судалгааны агуулга, үр дүнг та бүхэнд толилуулах болно. Төслийн зорилго нь авилгалын асуудлыг системтэйгээр судалж, түүнийг дэмжигч буюу өөгшүүлэгч, нөгөө талаас түүнийг сааруулах, хориглоход нөлөөлж буй хүчин зүйлс, нөхцөлүүдийг судалж шинжлэн бүлэглэн зэрэмбэлсний үндсэн дээр ахисан түвшний судалгааг нарийвчлан явуулах явдал байлаа. Энэ үүднээс авилгалд нөлөөлөгч хүчин зүйлсийг “дэмжигч”, “хориглогч” гэж ангилж, дотор нь “эдийн засгийн”, “улс төрийн”, “эрх зүйн”, “ зан заншил, ёс зүйн” хүчин зүйлсээр нь ялган, тус бүрээр нь олон нийтийн санаа бодлыг судлах, анализ хийх зорилт тавьж ажиллалаа. Төслийн судалгаанд судалгааны хэд хэдэн аргачлалыг зэрэгцүүлэн хэрэглэсэн. Ингэхдээ контент ба контекст анализын арга, тоон судалгааны анкетын арга, чанарын судалгааны фокус-группын ярилцлагын арга зэрэгт тулгуурлан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Үг тайлангийн гол дүгнэлт нь төслийн хүрээнд хийгдсэн 1/ авилгалын талаарх баримт материалын контент болон контекст анализ; 2/ 8 аймаг, нийслэлийн 6 дүүргийн төлөөлөл бүхий хот хөдоөг хамарсан нийт 500 гаруй түүвэр бүхий анкетын тоог судалгаа; 3/ тоон судалгааны үр дүнг бататгах, шалгах, тоон судалгаагаар илрээгүй судалгааны таамаглалыг тандах, судалгаагаар дэвшүүлсэн асуудлыг илүү нарийвчлан гаргах зорилгоор чанарын судалгааг фокус-группын ярилцлагын

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс дүгнэлтүүдэд үндэслэгдэж байгаа болно. Эдгээрийн гол агуулга, үр дүнг хураангуйлан авч үзвэл:

Төслийн багийнхан Монгол дахь авилгалын талаар хийгдсэн судалгааны материалуудыг цуглуулж системчлэн мөн үнэлгээ хийж ажиллалаа. Судалгааны ажлын дээрх чиглэлээр нийт 30 гаруй ном зохиол, 30 орчим сонини өгүүлэл, 10-аад эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, 10 баримт бичиг, 32 судалгааны ажлын тайлан, 3 гадаадын байгууллага, судлаачдын зүгээс өгсөн зөвлөмж, олон тооны мэдээлэл, ярилцлага зэргийг монгол, орос, англи хэл дээрхи ном материал, интернет, сонин сэтгүүл зэргээс үзэж судлан системчилж, хэрэгцээтэй, материалуудыг эмхтгэн авсан болно.

Баримт бичгийн контент-контекст анализын үр дүнд тулгуурлан авилгад эерэгээр болон сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлсийн хэмжүүр гарган бүлэглэн авч үзсэн. Үүнийхээ үндсэн дээр тоон судалгааг анкетын асуулгын аргад түшиглэн нийт 500 гаруй анкетаар тоон судалгааг явууллаа. Түүвэр судалгааны дүнг тооцож гаргахдаа авилгалыг өөгшүүлэгч болон хориглоход нөлөөлөх улс төр, эрх зүй, эдийн засаг, ёс суртахууны зэрэг хүчин зүйлсүүдийг хэд хэдэн дэд хүчин зүйлсээр тооцож гаргасан болно. Судалгаа авах цар хүрээг дараахи байдлаар тогтоон ажиллалаа. Үнд: Говь-Алтай аймгаас 36, Дорнод аймгаас 36, Эрдэнэт хотоос 40, Хөвсгөл аймгаас 36, Архангай аймгаас 45, Завхан аймгаас 36, Ховд аймгаас 40, Өвөрхангай аймгаас 31, УБ хотын Сүхбаатар дүүргээс 30, Баянгол дүүргээс 30, Сонгино хайрхан дүүргээс 30, Хан-Уул дүүргээс 30, Баянзүрх дүүргээс 30 Чингэлтэй дүүргээс 30 анкетаар тоон судалгааг явууллаа.

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Тоон судалгааг явуулахын тулд судалгааны нарийвчилсан асуултуудыг боловсруулж, анкетыг зохион хувилах ажлыг гүйцэтгэв.<sup>1</sup> Судалгааг 2006 оны YII-YIII сард хийж, судалгаанд оролцогсдын өгсөн мэдээллийг тоолж шалган, компьютерт шивж, статистикийн тоололтын боловсруулалтыг SPSS 11.5. программаар гүйцэтгэв.<sup>2</sup>

Судалгааны дараагийн үе шат болох чанарын судалгааг фокус-группын ярилцлагын аргаар авилгалыг дэмждэг болон хориглодог хүчин зүйлсийг тодруулан гаргах, улмаар тоон судалгааны үр дүнг чанарын судалгааны үр дүнтэй харьцуулсан судалгаа хийх зорилгоор явууллаа. Үүний тулд чанарын судалгааны асуултууд, ярилцлагын удирдамж, ярилцлагад оролцогчдыг сонгох асуулга, ярилцлага хетлэгчийн нэгдсэн хүснэгт, тэмдэглэл хетлэгчийн маягт зэрэг материалуудыг бэлтгэх ажлыг гүйцэтгэв. Фокус-группын ярилцлагыг нийт 4 бүлгээр 32 хүнийг хамруулан хийв. Судалгааг стандартын дагуу бэлтгэлийг бүрэн хангаж, сайтар зохион байгуулалттай явуулснаар тавьсан зорилгодоо амжилттай күрлээ. Ингэснээр судалгаанд оролцогсдын санал бодлыг үндсэн долоон асуудлаар системчлэн нэгтгэн гаргалаа.<sup>3</sup>

Чанарын судалгаа нь төслийн хүрээнд өмнө нь хийсэн тоон судалгааныхаа үр дүнтэй харьцуулан үзэж иргэдийн санаа бодлыг нарийвчлан гаргаж эдгээр үр дүнгүүдээ нэгтгэн анализ хийх зорилготой байсан билээ. Ингэснээр тоон болон чанарын судалгааг нэгтгэх, нэгдсэн анализ хийх боломжтой болсон.

Судалганд хэрэглэсэн анкетууд респондентуудын хариулсан байдлаараа баримт болон хадгалагдаж байгаа болно.

Судалгааны боловсруулалт хийгдсэн эх файл ба дүнг оруулсан, тоолол нийзэн файлууд баримт болон хадгалагдаж байгаа болно.

Далгэрэнгүй чанарын судалгааны анализ гэсэн хэсгээс үзнэ үү.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна.

Судалгааны тайлангийн хэсэг нь дотроо төслийн танилцуулга: үндэслэл, зорилт, аргачлал, зохион байгуулалт, авилгалын талаарх материалын баримтын шинжилгээ хийсэн дүн, тоон судалгааны анализ, чанарын судалгааны анализ, тоон болон чанарын судалгааны харьцуулалт, нэгдсэн анализ, дүгнэлт ба зөвлөмж, хүснэгт ба зураг, ном зүй гэсэн хэсгээс бүрдэж байна.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

### Төслийн үндэслэл, зорилт, аргачлал, зохион байгуулалт


Авилгалын асуудлыг шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс нарийвчлан судлах зүй ёсны шаардлагатай гэдэг нь өнөө цаг үед нэгэнт тулгамдсан асуудал болж байгаагаас харагдаж байна. 2005 онд АНУ-ын ОУХА-аас хийгдсэн "Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ" судалгаанд авилгал Монголд газар авч зөвлж байгаа нь илэрхийл байна<sup>4</sup> хэмээн тэмдэглэгдэж байсан бол харин МУИС-ийн Азийн Судалгааны төвийн санхүүжилттэйгээр хийгдсэн энэхүү төслийн хүрээнд хийгдсэн олон шатлалт ахисан түвшний судалгаанаас хараад авилгал "ноцтой" байдалд хүрсэн болох нь харагдаж байна.

Авилгал нь хөшигний цаана явагддаг, авсан, өгсний аль аль нь түүнийгээ нуухыг зорьдог зэргээс үүдэн нуугдмал шинжтэй байдаг. Тиймээс авилгалыг амархан хэмжих, судлан гаргах боломжгүй ч гэж үздэг. Гэвч нийгэмд газар авсаар буй, нийгмийн хөгжил давшил, ардчиллын үнэт зүйлст асар их хор хохирол учруулж буй авилгал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн эсрэг дорвитой зүйл хийх шаардлага зайлшгүй тулгарч буй учраас судалгааны багийнхан энэхүү төслийг зориглон авч ажиллалаа.

Өнгөрсөн хугацаанд Монголд авилгалын талаар хийгдсэн яллуудыг нэгтгэн авч үзвэл:

1996 онд "Авилгалын эсрэг хууль" батлагдан гарсан,

<sup>4</sup> United States Agency International Development, Assessment of Corruption in Mongolia, 19 August 2005 Final Report



- Үндэсний хэмжээнд суурь судалгааг 1997, 1999, 2002 онуудад тус тус хийсэн,
- 2002 онд "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр" батлан гаргасан,
- 2004 онд "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэнд мониторингийн судалгаа хийсэн,
- 2005 онд АНУ-ын ОУХА-аас "Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ"-ний тайланг боловсруулан гаргасан,
- "Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын авилгалтай тэмцэх төлөвлөгөө болон НҮБ-ын Авилгалын эсрэг конвенц зэрэг авилгалтай тэмцэх олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэх талаар Засгийн газар тодорохой үүрэг хүлээж буй,
- 2007 онд Авилгалтай тэмцэх тусгай байгууллагыг<sup>5</sup> байгуулсан,
- Иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагаар ихэнхи тохиолдолд олон улсын хандивлагч нарын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй авилгалтай тэмцэх сурталчилгаа хийх, авилгалд хяналт тавих болино болон дунд хугацааны хөтөлбөрүүд цөөн тоогоор хэрэгжиж ирсэн гэсэн дүн гарч байна.

Энэ бүхнээс үзвэл авилгалын эсрэг зохиосон ажлууд тооны хувьд боломжийн харагдаж байгаа. Гэхдээ тэдгээр судалгаануудыг харьцуулан судалж үзэхэд, дийлэнх хэсэг нь авилгал байна уу, үгүй юу гэдэг талаар хүмүүсийн санаа бодол ямар байгааг судлахад гол анхаарлаа төвлөрүүлсэн нь харагдаж байна.

Судалгааны өөр нэг аргачлал болох "авилгалын учруулсан

<sup>5</sup> Авлигатай тэмцэх газрын статусыг бие даасан, төрийн тусгай байгууллагын статустайгаар "Авлигын эсрэг хууль -ийн дерөвдүгээр бүлгийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааж өгсөн.

кохирлын хэмжээ болон оролцоог тогтоох" судалгааны аргачлалыг Монголд хараахан хэрэгжүүлж чадаагүй байна.

Төслийн багийн судалгааны зорилго нь өмнөх судалгаануудтай огтхон ч давхцаагүй бөгөөд асуудалд өөр өнцгөөс хандаж, өөрийн гэсэн зорилго, зорилтуудыг тавьж ажилласнаараа онцлог юм. Уг төслийн хурээнд авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийг судлан, ялан тодорхойлоход анхаарлаа илүү төвлөрүүлж ажилласан. Авилгалд нөлөөлөгч хүчин зүйлсийг "дэмжигч", "хориглогч" гэж ангилаад зогсохгүй дотор нь "эдийн засгийн", "улс төрийн", "эрх зүйн", " зан заншил, ёс зүйн" хүчин зүйлсээр нь ялан тодорхойлох асуудлыг нэлзэн нухацтай авч үзсэн болно.

Төслийн ажлаар дэвшүүлэн ажилласан гэл зорилтууд нь: манай нийгэм, улс төрийн амьдралд түгээмэл үзэгдэл болж газар авсаар байгаа авилгалын асуудлыг системтэйгээр судалж, түүнийг дэмжигч буюу өөгшүүлэгч, негөө талаас түүнийг сааруулах, хориглоход нөлөөлж буй хүчин зүйлс, нөхцөлүүдийг судалж шинжлэн бүлэглэн эрэмбэлсний үндсэн дээр ахисан түвшний судалгааг нарийвчлан явуулах, авилгалын асуудлыг шийдвэрлэх врэг замуудыг тодорхойлох, энэ талаар зөвлөмж боловсруулан гаргах зэрэг болно. Ингэснээр төслийн үр дүн нь нийгэмд шударга, чинийт өрсөлдөөнийг хэвшүүлэхэд нөлөөлөх, нийгмийн зүгээс төр зүйлийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудад тавих шаардлагыг үзүүлэх, үр дүнтэй болгох, авилгалтай тэмцэх талаар төр засгийн зүйзээ шийдвэр гаргах үйл явцад олон түмний санаа бодлыг тусгуулах зэрэг ач холбогдолтой юм.

Төслийн судалгаанд судалгааны хэд хэдэн аргачлалыг зэрэгцүүлэн хэрэглэсэн. Ингэхдээ контент ба контекст анализын арга, тоон судалгааны анкетын арга, чанарын судалгааны фокус-группын ярилцлагын арга зэрэгт тулгуурлан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Уг тайлангийн гол дүгнэлт нь төслийн хүрээнд хийгдсэн 1/ авилгалын талаарх баримт материалын контент болон контекст анализ; 2/ 8 аймаг, нийслэлийн 6 дүүргийн төлөөлөл бүхий хот хөдөөг хамарсан нийт 500 гаруй түүвэр бүхий анкетын тоон судалгаа; 3/ тоон судалгааны үр дүнг бататгах, шалгах, тоон судалгаагаар илрээгүй судалгааны таамаглалыг тандах, судалгаагаар дэвшүүлсэн асуудлыг илүү нарийвчлан гаргах зорилгоор чанарын судалгааг фокус-группын ярилцлагын дүгнэлтүүдэд үндэслэгдэж байгаа болно.

\* \* \*

Авилгал нь ардчиллын хөгжил цэцэглэлтэнд муу нөлөө үзүүлээд зогсохгүй ардчиллын замаас ухрахад ч хүргэх аюултай бөгөөд Монголчуудын санааг хамгийн ихээр зовоож буй асуудал болохын<sup>6</sup> хувьд судлаачид, иргэд, улс төрчид, олон улсын байгууллагуудын анхаарлыг татах болжээ.

Ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн өрсөлдөөнд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, хувийн ашиг хонжоо олох, бусад давуу байдал олгох нь тэгш, шударга өрсөлдөх боломжгүй болгож, жирийн иргэдийн хувьд өрсөлдөгч ба төрийн албан тушаалтан гэсэн хүч хавсарсан субъекттэй тэнцвэргүй

<sup>6</sup> AsiaBarometer 2005 survey: Mongolia profile

өрсөлдөөнд ороход хүргэж байна. Энэ нь улс төр, эдийн засгийн давуу байдал ямагт нэг тал, хэсэг бүлэг хүмүүсийн талд хадгалагдаж, бусад шударга өрсөлдөгчийг нухчин дарж үр дүнд нь нийгэм чанар муутай, сүл дорой үйлчилгээг хамгийн өндөр өртгөөр авахад хурдэг байна. Ингэснээрээ зах зээлийн зөв чиг голдрибоороо явах ёстой ардчилсан нийгмийн хөгжилтөнд саад бархшээл учирч эхэлдэг байна.

Авилгалын асуудал нь төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтуудтай холбогдон гардаг онцлогтой. Хувийн хэвшлийн гүбьект нь хамгийн оновчтой хувилбарыг сонгох туйлын эрмэлзэлтэй байдаг тул авилгал авах боломж бараг үгүй. Харин энэ онцлог нь төрийн албан хаагчидтай холбоотой ажил үйлчилгээ нийуулжад нь авилгал өгөгч болгон хувиргах боломжтой байдаг байна.

Нийгэм дэх авилгалын үйлдэл нь дараахь хэлбэрүүдээр оршиж байна. Үүнд:

албан тушаалын эрх мэдлээ ашиглан өөрийн албан үүрэгт хамааралгүй бусад байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх

албан тушаалын эрхийн дагуу асуудал боловсруулж шийдвэрлэхдээ хууль бусаар хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдах олгох

албан тушаалын хувьд өөртэйгөө ижил зэрэг дэвийн болон ширт захирагддаг албан тушаалтын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх

СУДАЛГААНЫ САН

- албан тушаалаа ашиглан хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож эд херенгө олж авах, бусдын эрхийг хязгаарлах
- дээрхи зорилгоор төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах зэрэг болно.

2003 онд Улаанбаатар хотноо болж өнгөрсөн Ардчилалыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлын<sup>7</sup> төгсгелийн баримт бичигт тусгаснаар мөнгө болон бэлэг сэлтээр хяналтын болон мөрдөн шалгах байгууллага, сонгуулийн ажиллагаа, тэр ч бүү хэл шүүхийг хахуульдаж болдог. Иймээс авилгал нь засаглалын байгууллага, тогтолцооны хууль ёсны дор тэсрэх бөмбөг тавьсантай адил гэж зүйрлэж үүнтэй тэмцэхийн тулд авч явуулж болох арга хэмжээнүүдэд дараах зүйлүүдийг оруулжээ. Үүнд:

- улсын албан тушаалтуудын зан үйлийн хатуу чанд дүрэм гаргах
- хээл хахуулиар олсон хөрөнгө буюу орлогыг угаах **боловжийг үүгүй хийх**
- сайн засаглалын практик болон цэвэр ариун байдлын нааштай эх суурийг нэвтрүүлэх
- улсын болон бизнесийн байгууллагуудын авилгальд автаж практиктай тэмцэх үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллагуудтай ажиллах
- авилга, хээл хахуульд өртсөн бүхнийг илрүүлж, мөрдөн шалгаж шийтгэх

<sup>7</sup> Тус хурал нь 2003 оны 9 дүгээр сарын 10-12-нд Улаанбаатар хотноо болж өнгөрсөн. Бага хурлыг Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын системийн байгууллагууд "Ардчилал, Сайн засаглал, Иргэний нийгэм" гэсэн сэдвийн дор зохион байгуулсан юм.

- улсын албан хаагчдад хахууль, шан харамж өгөхийг гэмт хэрэгт тооцох
- төрийн дээгүүр албан тушаалтууд өөрсдийн хувийн хөрөнгө болон өр төлбөрийн талаар зохих байгууллагад мэдээ гаргаж өгч байх
- хээл хахууль өгч авалцах явдлыг түмний соргог хараанаас мултрах аргагүй болгохын тулд улсын байгууллага дээр нарийн хяналт судалгаа явуулах, бүтцийн болон дүрэм журмын шинэчлэлт хийх асуудлыг нээлттэй хэлэлцэх
- авилгал, хээл хахуулийн боловжийг багасгахын тулд төрийн зохицуулалтын журмыг халах болон хялбарчлах
- гадаад орны төрийн албан хаагчдын хахуульдах үйлдэлд дотоодод мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчид болон үндэсний байгууллагуудын хууль эрх зүйн хэм хэмжээтэй хослуулан эрүүгийн хариуцлага хүлээнгэдэг болох
- омбудсмэн буюу авилгалтай тэмцэх комиссуудын хүчийг ашиглан хяналт шалгалтын болон албадлагын арга хэмжээ авах зэрэг болно.<sup>8</sup>

Монгол Улс "Авилгалын эсрэг хууль"-ийг 1996 оны 4-р сард, Зураг 18 зүйлтэйгээр баталсан бөгөөд уг хуулинд зааснаар "Аннагал гэж ... хээл хахууль авах, хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, зорилж ашиглах, ийнхүү ашиглуулахаар түүнд шан харамж бууру хөнгөлөлт, давуу талыг хувь хүн, хуулийн этгээдээс олгох явцыг ойлгоно" хэмээн тодорхойлсон бөгөөд "Авилгалтай тэмцэх

СУДАЛГААНЫСАН

Аннагалыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага судалгааны ажлууд ба төгсгелийн баримт бичгүүдийн эмхэтгэл, УБ.,

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс  
үндэсний хөтөлбөр"-ийг УИХ-ын 2002 оны 7-р сарын 4-ний өдрийн  
41-р тогтоолоор баталжээ.

Манай улсад авилгалын талаар МНХХ санхүүжилтээр 1999 онд, MYXAYT-aas 2002 онд, Транспэренси Интернэйшнл байгууллагаас 2004 онд, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилтээр 2005 онд тус тус томоохон судалгаанууд хийгджээ. Эдгээр судалгаанууд нь монгол улс дахь авилгалын байдлыг үнэлэхэд голлон чиглэгджээ. Харин бидний хийсэн судалгаа нь авилгалын байдалд үнэлгээ өгөхийн зэрэгцээ түүнийг арилгахад ямар хүчин зүйлийг ашиглах хэрэгтэй байна вэ гэдэгт голлон анхаарсан билээ.

Ингээд төслийн хүрээнд хийгдсэн баримтын шинжилгээ, тоон болон чанарын судалгааны нарийвчилсан анализ, судалгааны хэсгийг дараах хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

#### Авилгалын талаарх материалуудад хийсэн анализ

Баримт бичгүүдэд анализ хийх судалгааны үйл ажиллагааны хүрээнд тэдгээр баримт бичгүүдийг хэд хэдэн хэсэг болгон ангилж болохоор байна. Тухайлбал:

- Авилгалын талаарх шинжлэх ухаан-онолын судалгаа анализад тулгуурлан хийгдсэн нэг сэдэвт зохиол бүтээлүүд, нэгдсэн аргачлал, зөвлөмж бүхий гарын авлага;
- Олон улсын байгууллага, сан, төслийдийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр авилгалын талаар хийгдсэн судалгаа, теслүүд, тэдгээрийн тайлан, үр дүнг илэрхийлсэн баримт материалууд;
- Тер засгийн зүгээс батлан гаргасан, хууль эрх зүйн актууд, котелбор, бодлогын шинжтэй баримт бичгүүд;
- Авилгалтай тэмцэх талаар голчлон хийгдсэн олон улсын курал, зовлögөөний баримт бичгүүд, зөвлөмжийн шинжтэй уриалга, холбогдох бусад материалууд;
- Судалгаа, шинжилгээний зорилго, зориулалттай биш боловч авилгын талаарх ухуулга, сурталчилгаа, нийгмийн танин мэдэхүйн шинжтэй, нийгмийг авилгалаас ангижруулах арга зам эрэлхийлсэн, авилгалтай тэмцэх боломжийн талаар голчлон анхаарсан олон нийтийн мэдээллийн хэрэгслийн материалууд;
- Авилгалтай холбоотой гарсан бусад материалууд зэрэг болно.

ИНГХН  
СУДАЛГААНЫ САН

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Судалгааны ажлын дээрх чиглэлээр нийт 30 гаруй ном зохиол, 30 орчим сонины өгүүлэл, 10-аад эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, 10 баримт бичиг, 32 судалгааны ажлын тайлан, 3 гадаадын байгууллага, судлаачдын зүгээс өгсөн зөвлөмж, олон тооны мэдээлэл, ярицлага зэргийг монгол, орос, англи хэл дээрхи ном материал, интернет, сонин сэтгүүл зэргээс үзэж судлан системчилж, хэрэгцээтэй материалыудыг эмхтгэн авсан болно. Баримт материалыудад нэгдсэн анализ хийх явцад авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийн талаар өөрөөр хэлбэл бидний төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилтай адил төстэй судалгааны материал бараг байхгүй юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн болно.

Нийт судалж үзсэн 130 гаруй материалаас харахад авилгалын асуудал нь нийгэмд асар их хор хохирол учруулдаг бөгөөд манай орны өнөөгийн нөхцөлд энэ нь нэн их анхаарал татсан, өргөн цар хүрээг хамарсан үзэгдэл болохын хувьд судлаачид, иргэд, улс төрчид, гадаадын янз бүрийн байгууллагуудын анхаарлын төвд байж, судалгааны ажилд нилээд их хүч хөдөлмөр, санхүүжилт зарцуулагдсан нь харагдаж байна.

Судалгааны багийнхан Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн, АНУ-ын Олон улсын хөгжлийн хүрээлэн, НҮБХХ, Дэлхийн банк, АНУ-ын Элчин сайдын яам, Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн, Бээжин дэх Нидерландын вант улсын Элчин сайдын яам, Глоб Интернейшнл зэрэг гадаадын олон байгууллагын санхүүжилтээр хийгдсэн судалгааны ажлуудтай нарийвчлан танилцсан болно.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Юуны өмнө, авилгалын талаарх судалгааны материал, ном, баримт бичгүүд, хууль эрх зүйн акт зэрэгт нарийвчилсан анализ хийв. Эдгээр материалыг үзэж судлах явдал нь бидний хийж буй судалгааны ажилтай адил төстэй зүйлүүд эдгээр материалыудад байна уу, хэрвээ байгаа бол ямар түвшинд боловсрогдсон байна вэ гэдгийг тодруулахад анхлан чиглэгдсэн болно. Түүнчлэн авилгалын асуудлыг аль салбар, чиглэлээс нь илүү анхаарсан байна вэ гэдгээр нь ангилж бидний судалгааны ажилтай давхцаж болох, судалгааны ажилд чухал ач холбогдолтой байж болох материалыудыг ялгаж ангилж үзлээ. Ингэж ангилж үзэхэд авилгалыг гэмт хэрэг гэж үзэж, илрүүлэх, хуулийн хариуцлага хүлээлгэх талаас нь, өмч хувьчлалыг хуудуутай хийж улсын өмчийг үрэн таран хийсэн гэдэг талаас, мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүй, авилгалыг арилгахад тэдний нийгэмд гүйцэтгэх томоохон үүргийн талаас анхаарч үздэг нь тодорхой харагдаж байна.

Төр засгийн зүгээс ч авилгалтай тэмцэх талаар нилээд арга хэмжээ авдаг нь хуулийн төслүүд, саналууд, батлаж гаргасан кууль, хөтөлбөрүүд, баримт бичгүүдээр нотлогдож байна. Авилгалтай тэмцэх талаар олон улсын хурал зөвлөгөөний материалыуд ч нилээд байгаа ба гадаадын улс орнуудын авилгалтай тэмцсэн, өндөр албан тушаалтан, эрх мэдэлтнүүдийн хуудуутай үйл ажиллагааг илчилсэн арга туршлагыг хуваалцсан шинжтэй материалыуд чамгүй орчуулагджээ.

Судалгааны зориулалтай биш, харин эрх баригчид, улс төрчид авилгал авч байгаа гэж үзэж нотлохыг оролдсон нийгэмд учруулсан хор хохиролтой үр дүнгээс нь ургуулан авилга авсан байж магадгүй гэж таамагласан, нийгмээ авилгалаас ангийн улах

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс арга зам хайсан сонин, хэвлэлийн материалууд асар их байна. Магадгүй бараг өдөр бүр хэвлэгдэж байдаг эдгээр материалууд нь авилгалын асуудал монголд бараг бүрэн судлагдсан гэсэн сэтгэгдэл төрүүлдэг байж болох юм.

Гэтэл судалгааны багийнхан хуваарилан авсан материалуудаа нэгтгэн хэлэлцэх явцад авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийн талаар өөрөөр хэлбэл бидний төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилтай адил төстэй судалгааны материал бараг байхгүй юм байна гэсэн нэгдсэн дүгнэлтэнд хүрсэн болно. Мэдээж хэрэг нөлөөлөгч хүчин зүйлсийг гаргахыг оролдсон оролдлогууд олон байгаа нь харагдаж байна. Гэвч нийгэм, улс төрийн амьдралын хүрээнд бүхэлд нь, цогцоор нь гаргах тал дээр учир дутагдалтай байгаа юм.

Бидний төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилтай нилээд төстэй байж болох, бидний ажилд нилээд их ач холбогдолтой цөөхөн хэдэн судалгааны ажил байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. Энд юуны өмнө MYXAYT, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн хамтран 2002 онд хийсэн Улс төрийн хүрээний авилгалын индекс судалгаа, Засгийн газрын "Сайн засаглал" хөтөлбөрийн хүрээнд 1999, 2002 онд авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурин судалгаанууд нь бидний төслийн ажилд нилээд ач холбогдолтой, авилгалд нөлөөлж буй хүчин зүйлсийн өөрчлөлт, төр засгаас явуулж буй үйл ажиллагааны үр дүнг харьцуулж авч үзэхэд зарим талаар дэхэмтэй материалууд байгаа болно. Мөн Жереми Поупын "Авилгалын эсрэг сурвалж бичиг" хэмээх ном нь бусад орнууд дахь авилгалын нөхцөл байдлыг манай орны нөхцөл

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс байдалтай харьцуулан үзэхэд чухал ач холбогдолтой материал билеон.

Ингээд анализ хийсэн зарим судалгааны материалуудын талаарх төп дүгнэлтүүдийг тоймлон авч үзье.

Ц.Самбалхүндэв, Ж.Оюунтуяа нарын 2001 онд гаргасан Монгол Улсын Засгийн газрын "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал" хөтөлбөрийн бодлогын баримт бичиг бүтээлд Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, хөтөлбөрийн зорилтуудыг томьёолсон байна. Монгол дахь хүний аюулгүй байдалд учирч буй аюул заналын нэг гол хүчин зүйл нь авилгал гадаа угтаар тусгасан ном байлаа.

Энриг сангаас эрхлэн "Өнөөдөр эсвэл хэзээ ч ..." гэсэн эмхэтгэлийг 2002 онд хэвлүүлж гаргасан. Уг эмхэтгэл нь зурагт хуудас, сонины шийтгэл зэргийг багтаасан ба нийгэмд авилгал, хээл хахуулийг шиншэхэд гол зорилгоо тавьсан, харин судалгааны бүтээл биш юм.

2002 онд Монгол Улсын ЗГХЭГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнангээний хэлтсийн "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг дэмжих төслийн удирдлагын нэгж"-ээс эхнэн гаргасан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт, үүн үр дүн" номонд тодорхой экспертийн хэсэг ЗГХЭГ-ын болон замын холбогдох нэгжүүдийг оролцуулан "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал" хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн баримт, түүний хэрэгжилтэнд нэг жил хагасын байдлаар мониторинг хийсэн аргачлалыг тусгажээ.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Зориг сангаас 2002 онд эрхлэн гаргасан "Сайн засаглал" ном нь Зориг сан, БНОУХ-ээс хамтран 2001 онд зохион байгуулсан олон улсын бага хурлын илтгэлүүдийг эмхтгэл бүтээл юм. Тус бага хурал 1/ сайн засаглалын тухай, 2/ ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, 3/ авилгалтай тэмцэх нь, төрийн албан хаагчийн ёс зүй, 4/ сайн засаглалыг бүрдүүлэхэд иргэний нийгэм ба хувийн хэвшлийнхний үүрэг оролцоо гэсэн 4 сэдвээр явагджээ.

2003 онд АШСТО-ын 5-р бага хурлыг зохион байгуулах комиссын бэлтгэн гаргасан "Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл" ном нь 359 хуудастай, монгол, англи хэл дээр хэвлэгдсэн байна. Уг номонд 2003 онд "Ардчилал, сайн засаглал, иргэний нийгэм" сэдвийн доор явагдсан бага хурлын 13 судалгааны ажил, 3 тойм өгүүлэл, хурлын төгсгөлийн баримт бичгүүд оржээ.

Баренц бүлэг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аас эрхлэн гаргасан "Монголын өмч хувьчлал" хөтөлбөр, "Хувьчлал: түгээмэл асуулт, бодитой хариулт" гэсэн бүтээлд анализ хийв. Энэ товхимолд Монгол улсад явагдсан өмч хувьчлалын талаар гарч байсан янз бүрийн мэтгэлцээнүүдэд дүгнэлт хийж, оновчтой арга зам боловсруулах зорилго тавьжээ. Гол нь өмч хувьчлалын явцад төв болон орон нутгуудад гарч байсан алдаа оноонуудад дүгнэлт хийсэн. Харин улс төрийн амьдрал, улс төрийн албан тушаалтууд эдийн засгийн салбарт ямар нелөөтэй байна, эдгээрийн хоорондын уялдаа холбоонд чухам юу нелөөлж байна вэ гэдэг чухал асуудал нэг их тусгагдаагүй байна.

"Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт" хэмээх төслийн хүрээнд бизнесийг дэмжих таатай орчны бүрдүүлэлтийн судалгааг Бээжин

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

дэд Нидерландын Вант улсын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр 2004 онд явуулжээ. Уг судалгааны гол зорилго нь Монгол улсад бизнес эрхлэхэд тохиолдож байгаа бэрхшээлүүдийг гаргаж тэдгээрийг шийдэх арга замыг эрж хайх явдал байжээ. Судалгаагаар тохиолдож байгаа олон бэрхшээлүүдийг гаргаж явысан бөгөөд эдгээрээс авилгалын асуудлыг нэлээд том барихаан гэж үзсэн. Гэхдээ авилгалд өөрт нь анализ хийж мөн цанарыг эрж хайх талаар төдийлэн анхаараагүй. Судалгааны зорилго ч дан ганц авилгалын асуудал байгаагүй юм байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр "Бизнесийн хүрээн дэх авилгал" замаар судалгааг 2000 онд явуулсан. Уг судалгаагаар улс орны эмжээнд хөгжлийг саатуулагч нэг гол хүчин зүйл нь авилгалын хүлээн зөвшөөрсөн. Судалгааны гол зорилго нь бизнесийн таатай орчинг бий болгоход тулхүү анхаарсан. Харин шингмийн амьдралын бусад хүрээнд авилгалын хор нөлөө, шингмийг дэмжээнд байгаа хүчин зүйлүүд гэдэг талаас төдийлөн шинэ узэгүй байна.

Олон улсын бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтынг хахуульдах явдалтай тэмцэх тухай конвенц" нь 1997 онд батлагдсан олон улсын хэмжээнд төрийн албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээг тусгасан чухал баримт бичиг юм. Харин авилгалд нөлөөлөх хүчин зүйлийг гаргах нь уг баримт шингийн зорилго биш. Гэхдээ бидний судалгаанд ач холбогдол бүхий эх сурвалжийн нэг болж байгаа юм.

СУДАЛГААНЫ САН

Гlob Интернэйшнл ТББ нь 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн дүng гаргажээ. Энэхүү мониторинг нь Ерөнхийлөгчид нэр дэвшигчид болон тэдний мэрийн хөтөлбөрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд хэр зэрэг бодитой, тэнцвэртэй мэдээлэл хүргэж байгааг үнэлэх зорилго тавьсан. Яг авилгалын асуудалтай холбоотой судалгаа биш боловч хэвлэлүүдэд гарч байгаа мэдээ, мэдээллүүд нь төрийн дээд албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой байдаг гэсэн утгаараа бид судалгаандаа зохих хэмжээгээр ашигласан болно.

Ж.Нэргүйн бичсэн "Төрөө завхруулж, түмнээ хуурсан шаштири" I, II хэмээх 2 дэвтэр бүтээл 2003 онд хэвлэгдэн гарчээ. Энэ нь 2000-2004 оны хооронд "Түмнээ ядуурлаас, төрөө хямралаас гаргана" гэж амлаж гарч ирсэн эрх баригчид авилга хээл хахуультай холбоотой ямар ямар хэрэгт нэр холбогдож вэ гэдгийг харуулахыг зорьсон. Гэхдээ энэ бүтээл нь эрдэм шинжилгээний ач холбогдол төдийлөн их биш, харин гол төлөв зохиогч өөрийн ямар нэг дүгнэлт үнэлгээ хийхийг зориогүй, зөвхөн чөлөөт хэвлэлүүдэд гарч байсан сенсацитай материалуудыг л эмхэтгэхэд анхаарсан байгаа юм.

Зориг сангаас эрхлэн "Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нэр их хөдөлмөр" эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага гэсэн номыг ЮНЕСКО-гийн санхүүжилтээр 2004 онд монгол хэлнээ хөрвүүлэн гаргасан байна. Энэ ном нь Филиппин улсын ерөнхийлөгч Эстрадагийн авилгалын үйл ажиллагааг илчлэн огцруулахад хүргэсэн Филиппины Эрэн Сурвалжлах төвийн үйл ажиллагааг харуулсан бүтээл юм. Уг ном авилгалыг таслан

зөвхөөхөд хэвлэл мэдээллийн хэрэгслэл ямар их үүрэг гүйцэтгэж болохыг харуулснаараа сэтгүүл зүйн маш их ач холбогдолтой бутааз болсон гэж узэж байна.

Марк Грамбергер, 2003. "Иргэн түншлэгч болох нь: Бодлого билжиреуулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг ширгүүлах" хэмээх ном нь 112 хуудастай, монгол, англи хэл дээр хэвлэгдсэн бүтээл байлаа. ЭЗХАХБЫН захиалгаар бичигдсэн номыг МННХ санаачлан орчуулжээ. Уг номонд шийдвэр гаргах үйл явцын бух шатанд иргэд, сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах нь ил тод байдлыг бий болгон бодитой шийдвэр гаргахад нөлөөлж, улмаар авилгалын эсрэг чиглэсэн үйл ажиллагаа болдгийг, үүнд мэдээлэл холбооны технологийн дэвшигийг хэрхэн ашиглах талаар тохиосон практик удирдамжийн шинжтэй гарын авлага байлаа.

МУХАҮТ-аас "Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь" сэдэвт семинарыг 2002 оны 2 сарын 28-нд зохион явуулсан бөгөөд энэ семинарын материалыаа товхимол болгон хэвлүүлсэн байна. Энэ сургалт семинарт С.Нарангэрэл, Ц.Дашдондов, Д.Ламжав, Ч.Нэргүй нарын манай нэртэй хуульч, сэтгүүлч, эдийн засагч зэрэг хүмүүс лекц үзүүлж авилгалын хор уршиг, онцлог шинж, авилгалын эсрэг үйл явиллагаа, авилгалын төрөл шалтгаан, авилга ба хэвлэл мэдээллийн байгууллага, эрх зүйн орчин зэрэг асуудлыг өөр өөрсдийн мэрэжлийн чиглэлийн дагуу гаргаж илтгэл тавьсан байна. Түүнчлэн зарим нэг санал асуултын дүng ч нэгтгэн харуулсан байна.

И.Базар 2003 онд "Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ" хэмээх номоо хөнгүүлсэн байна. Энэ ном нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга

### Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

барил, эх сурвалжтай хэрхэн харьцах, эрэн сурвалжлах явцад тохиолдож болох бэрхшээлүүд, сэтгүүл зүйн хариуцлагатай байдал зэргийг гаргаж тавьсан сэтгүүлчдийн хувьд үнэ цэнэтэй бүтээл юм. Эрэн сурвалжлага хийхэд монгол улсад тохиолдож байгаа онцлог, бэрхшээлүүд, эрх зүйн орчин, хараат бус байдал, цензурын асуудлыг гаргаж тавьсан. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд улс төрийн хүчин бүлэглэлүүдийн гар хөл болон хөгжиж байгааг жишээ баримтандтулгуурлан авч үзжээ. Энэ бүтээлд авилгалын асуудлыг тусгайлан судлаагүй боловч сэтгүүл зүй нийгмийг эрүүлжүүлэхдээ жинтэй хувь нэмэр оруулах хүчин зүйл гэдэг талаас нь тайлбарласнаараа ач холбогдолтой юм

Ингээд, авилгалтай холбоотойгоор батлан гарсан зарим хуулиудын онцлох заалтын талаар авч үзье.

"Авлигын эсрэг хууль"-д авлигын талаар тодорхойлоходоо албан тушаалтан эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах явдалтай холбон тодорхойлсон байдаг. Авлигыг өгөгч, авагч хоёр талын аль алины үйлдэл, эс үйлдлийг эрх зүйн зөрчилд тооцон үүнийгээ авлига гэсэн нь нэлээн ерөнхий байдлаар авч үзсэн хэрэг болжээ.

Тус хуульд зааснаар Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй гэсэн. АТГ-ын гаргасан шийдвэр авлигатай холбоотой асуудлыг хөндсөн байх нь мэдээж. Гэтэл үүний дагуу тухайн байгууллага өөрсдөө арга хэмжээ авч, үүнийгээ тус газарт мэдэгдэнэ хэмээсэн нь асуудлыг шийдэх эрх нь хаана байгааг бүрхэг болгож өгч байна. Тус хуулийн 6.8.-д

### Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

зааснаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сакилгын шийтгэл хүлээлгэнэ.

Албан тушаалтнуудад хориглох зүйлсийн талаар тус хуулинд хэрхэн тусгагдсаныг авч үзвэл, хуулийн 7.1.2.-т албан тушаалынхаа бүрэн эрхийн дагуу асуудал боловсруулж шийдвэрлэхдээ хууль бусаар аль нэг хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох; 7.1.3.-т албан тушаалын хувьд ижил зэрэг давийн болон өөрт нь захирагддаг буюу хяналт тавьдаг албан тушаалтны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх; 7.1.4.-т албан тушаалынхаа байдлыг ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, хууль бусаар бусдад давуу байдал олгох, бусдын эрхийг хязгаарлах, төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах; 7.1.5.-д албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бусаар ашиг хонжоо олох, бусдад давуу байдал олгох зорилготой бусад үйлдэл хийх зэргийг албан тушаалтнуудад хориглосон байна.

Авлигатай тэмцэх газрыг төрийн тусгай байгууллагын бийтийгээр тус хуулинд зааж өгсөн бөгөөд түүний эрх, үүргийн шуудлыг 15.1.-д Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон шийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, ширдэн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн замаан тодорхойлжээ. АТГ-ыг өөрчлөн байгуулах, татан буулгах шуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг

үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэхээр зааж өгснөөрөө төрийн эрх барих дээд байгууллагын онцгой эрхийг улам нэмэгдүүлсэн хэрэг болжээ. Харин тус хуулин дахь нэн чхуал асуудал бол авлигатай тэмцэх асуудалд олон нийтийн оролцоог институчлэх талаар авч үзсэн явдал юм. Хуулийн 27.1.2-д авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана гэсэн нь олон нийтийн оролцооны хувьд дэвшилттэй алхам болсон. Гэвч орон тооны бус гэсэн статусаар хариуцлага ба эрх хэмжээний асуудлыг бүрхэгдүүлсэн байж болох талтай юм. Бүрэлдэхүүний хувьд тус олон нийтийн зөвлөл нь 15 гишүүнтэй байх ба зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно гэжээ.

Ингээд авч үзэж байгаа асуудалтай холбогдуулан зарим хуулиудын заалтыг дурдвал:

"Төрийн албаны хууль"-д төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно хэмээн заасан байдаг нь санамсаргүй хэрэг бишээ. Хэдийгээр тус хууль өмнө авч үзсэн "Авлигын эсрэг хууль"-аас өмнө батлагдсан боловч төрийн албан хаагчийн үйл ажиллагаагаа явуулах хамгийн гол зарчмыг зааснаараа нэн ач холбогдолтой болжээ. Төрийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн эрх үүрэг авилгалаас ангид байх гол үндэс нь тухайн албан хаагч албан тушаалын зэрэглэлээс үл хамааран өөрийн бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах аливаа асуудлыг "урвуулан" буюу сөргөөр ашиглахгүй байх явдал юм.

Энэ нь зөвхөн эрх зүй, улс төрийн хариуцлага үүднээсээ хамаатай таадийгүй хувь хүний ёс суртахууны өндөр чадвар шаарддаг ажээ. Албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэхийг хориглохоор зохицуулснаараа авилгалын эсрэг гол үзэл санаа, зарчмыг "Төрийн албаны хууль" нь "Авлигын эсрэг хууль"-аас дутахааргүй хөндсөн гэдэг нь карагдаж байна.

Тэгээд ч "Төрийн албаны хууль"-ийн 6.2.-д аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно гэсэн нь дээрх түвшний албан тушаалтуудад улс төрийн хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг гаргаж өгсөн байна. Авилгалын асуудал улс төрийн хариуцлагатай салшгүй холбоотой гэдгийг нурших шаардлагагүй юм.

Улс төрийн харилцаанд гол үүрэг гүйцэтгэдэг институт болох улс төрийн намын талаарх харилцааг зохицуулсан "Улс төрийн намын тухай хууль"-д өмнөх хуулиудтай үзэл санаа ойролцоо заалт цөвнгүй байдаг. Хэдийгээр энэ хуулийг улам боловсронгуй болгох санаачилга нийгмийн зүгээс ч тэр улс төрчдийн зүгээс ч тэр хуулийн үед нэлээн тавигдаж байгаа боловч холбогдох зарим зохицуулалтанд анхаарлаа хандуулья.

СУДАЛГААНЫ САН

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Тус хуулийн 7.1.-д намын зүгээс төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно гэсэн нь чухал ач холбогдолтой санааг илэрхийлж байгаа. Түүнчлэн 7.2.-д төрийн жинхэнэ албан хаагч албан үргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэгэн намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно гэсэн байна. Эдгээр заалт нь дээр дурьдсан “Төрийн албаны хууль”-д заасан төрийн үйл ажиллагааны гол зарчмыг давтан бааталгаажуулж байгаа нь харагдаж байна. Гагчүү шүүмжлэлтэй асуудал нь эдгээр хуулийн үзэл санаа амьдралд хэр зэрэг бодитой хэрэгжиж, үйлчилж чадаж байна вэ гэлэгт оршиж байна.

Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая, иргээдээс нэг сая төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно, нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна зэрэг зохицуулалт яах аргагүй улс төрийн институтыг авилгалаас ангид үйл ажиллагаа явуулахыг эрх зүйн үүднээс тулгаж байгаа хэрэг болжээ. Эрх зүйн хүчин зүйлс ийнхүү улс төрийн институтын үйл ажиллагаанд нөлөөлж буй талаар тоон болон чанарын судалгааны анализ хэсэгт нарийвчлан тайлбарлах болно.

“Улс төрийн намын тухай хууль”-ийн 19.1.-д Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

үзүүлнэ, 19.2.-д Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд өрвэн сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн бонгуулийн тойрот явуулах үйл ажиллагаанд зарцуулна хэмээн тус тус заасан байгаа нь улс төрийн намын санхүүжилтийн процесс олон түмэнд нээлттэй байх санааг давтан илэрхийлж, улмаар түүний зарцуулалтын хүрээ хязгаарыг хуулиар тодорхойлж өгсөн хэрэг болжээ.

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-д намын санхүүжилтийн асуудал УИХ-ын сонгуулийн үеэр хэрхэн явагдах боломжийг тодорхойлон зохицуулсан байdag. Тус хуулийн 41.1.-д нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ хувь хүнээс 1 сая төгрөг, хуулийн этгээдээс 3 сая төгрөг байна, 42.2.-д нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлланг бичил хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ хэмээсэн нь намын төдийгүй бие даан сонгуульд оролцож буй субъектын хувьд ч сонгуулийн үүйн санхүүжилтийг авилгалаас болон хууль бус аливаа мөнгөн тусламж, дэмжлэгээс хараат бус байх зайлшгүй шаардлагыг илэрхийлжээ. Тэр ч байтугай хуулийн 42.3.-д нам, эвсэл дээр тодорхойлогдсон сонгуулийн зардлын тайландаа хөндлөнгийн хийнчилгээний шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулсан байхыг хуульчлан заажээ. Энэ бүхэн нь авилгальн асуудал дан ганц “Авлигын эсрэг хууль”-аар зохицуулагдах явцуу хэрэг биш болохыг баруулж байгаа юм.

СУДАЛГААНЫ САН

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

"Газрын тухай хууль"-ийн 57.3.-д зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө гэсэн байдаг. Энгийнээр ойлгоход зөвшөөрөлгүй барьсан нь тодорхой баримт байхад тухайн Засаг дарга газар чөлөөлөх мэдэгдэл өгөхгүй байгаа тохиолдолд үүнийг авилгалтай холбон авч үзэх бүрэн боломжтой юм. Мэдэгдэл заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна гэдэг нь мөн л өмнөх санааг олж харах боломжтой заалт болжээ.

Дашрамд дурьдахад, судалгааны судлах зүйлтэй холбогдуулан авч үзсэн дээрх хуулиудын талаарх судлаачдын багийн тайлбар, үзэл санаа нь хуулийн албан ёсны тайлбар биш гэдгийг онцлох нь зүйтэй юм.

2002 онд батлан гаргасан Монгол улсын "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр" нь :

1. Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох
2. Авилгалаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх
3. Төрийн албыг боловсронгуй болгох
4. Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах
5. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээнүүд
6. Эдийн засгийг либеральчлах
7. Авилгалтай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Гасан үндсэн 7 чиглэлээр, 30 гаруй зүйл заалттайгаар боловсрогдон гарсан байна. "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөлийн даргаар УИХ-ын дэд дарга, дэд даргаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороон дарга, гишүүдээр нь Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, яамдын сайд наар томилогджээ. Гэвч уг хөтөлбөр нь маш ерөнхий шинжтэй, хэрхэн хэрэгжүүлэх арга механизмын тодорхой бус, хэн хэрхэн хариуцах, яаж хяналт тавих нь тодорхой бус явж иржээ.

Гэхдээ "Авилгалын эсрэг хууль" болон авилгалтай шууд болон дамжуулбоотой бүхий л хууль, тогтоомжуудын хэрэгжилтэнд бүгдэд нь үнэлгээ хийх нь боломж муутай зүйл юм. Учир нь Монголд өнөөдөр авилгал "терийн эрх мэдлийг ашиглан санхүүгийн асуудлаа шийдвэр болох бараг бүх газар, цаг үед гарч байна" гэж болохоор байгаа нөхцөл байдал үүсээд байна.

"Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-т заагдсан дээрх чиглэлүүдтэй авч үзсэн хуулиуд шууд холбогдож байгааг анхаарах баргатай. Эдийн засгийг либералчлах нь авилгалаас сэргийлэх, түүнийг хориглох эдийн засгийн гол арга хэмжээ болно гэсэн банааг бидний хойно авч үзэх чанарын судалгааны анализ хэсгээс дэлгэрэнгүй үзэж болно.

Харин авилгалтай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог "Авлигын эсрэг хууль"-д олон нийтийн оролцоотой орон тооны бус зөвлөлийг АТГ-ын дэргэд байгуулахаар зааж өгснөөр хязгаарлаж ойлговол нийроосгөл хэрэг болно гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

## Тоон судалгааны анализ

Төслийн хүрээнд хийсэн тоон судалгааг хот хөдөөг хамруулан 500 гаруй анкетаар явуулсан бөгөөд улмаар судалгаа авах цар хүрээг дараахи байдлаар тогтоон ажиллалаа. Үүнд: Говь-Алтай аймгаас 36, Дорнод аймгаас 36, Эрдэнэт хотоос 40, Хөвсгөл аймгаас 36, Архангай аймгаас 45, Завхан аймгаас 36, Ховд аймгаас 40, Өвөрхангай аймгаас 31, УБ хотын Сүхбаатар дүүргээс 30, Баянгол дүүргээс 30, Сонгино хайрхан дүүргээс 30, Хан-Уул дүүргээс 30, Баянзүрх дүүргээс 30 Чингэлтэй дүүргээс 30 зэргээр нийт 500 гаруй анкетаар тоон судалгааг явууллаа. Үүнийг хүснэгт 1.-ээс харна уу. Хот, хөдөөг хамарсан 500 гаруй анкетаар явуулсан тоон судалгааны дүнг авч үзвэл дараахи зүйлс ажиглагдлаа.

Хүснэгт 2.-оос харахад судалгаанд хамрагдагсдын хүн амын хувийн жинг авч үзвэл, нийт судалгаанд оролцогсдын 58,6 % нь дээд боловсролтой, 24,3% нь бүрэн дунд, 17,0 % нь тусгай дунд боловсролтой байна. Ажил эрхэлж буй салбарын хувьд авч үзвэл, төрийн байгууллагад ажиллагсад судалгаанд оролцогсдын 46,9%-ийг эзэлж байгаа бол хувийн хэвшлээс 19,7%, төрийн бус байгууллагын 5,7%, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 16,4%, ажилгүй хүмүүс 11,4%-ийг тус тус эзэлж байна.

Өрхийн сарын дундаж орлогын хувьд 50001-250000 төгрөгийн орлоготой буюу олонлогийн хувьд дундаж хэсгийг эзэлж буй хувийн жин нийт судалгаанд оролцогсдын 71,2%-ийг эзэлж байгаа юм. Энэ нь оролцогчдын хувьд дундаж түвшний эдийн засаг, санхүүгийн боломжтой гэж болохоор хүмүүс дийлэнх болохыг илтгэж байна.

Түүвэр судалгааны асуулгыг сонгох, хариултын хувилбарыг гаргах, дүнг тооцож гаргахдаа авилгалыг өөгшүүлэгч болон хориглоход нөлөөлөх улс төр, эрх зүй, эдийн засаг, ёс суртахууны зэрэг хүчин зүйлсүүдийг хэд хэдэн дэд хүчин зүйлсээр авч үзсэн болно. Түүнчлэн авилгал, хээл хахуулийг багасгахад ач холбогдолтой дараах хүчин зүйлсүүдээр судалгаанд хамрагдагсдын хариулсан байдлыг авч үзвэл: авилгал авдаг төдийгүй өгч буй этгээдэд 46,2% нь, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм баталж, чанд сахиулахад 47,7% нь өндөр ач холбогдол өгсөн байдал харагдаж байна (Хүснэгт 7-г харна уу).

Үүнээс үзэхэд хориглогч хүчин зүйлсийн талаарх ойлголт нийгмийн сэтгэл зүйд нэгэнт бүрдсэн байна гэж болох юм. Харин энэ талаар төрийн бодлогын хэмжээнд дорвitoй арга хэмжээ авах нь зүйтэй.

Санамсаргүй түүврийн аргаар, ингэхдээ хүн амын тархалтын байдлыг харгалzan асуулга аваходаа бэлдсэн хариултуудаар буюу хвалттай асуулгын аргыг ашигласан. Учир нь нэгэнт судалгааны зорилго авилгалын хүчийн зүйлсийг тодруулах, ангилахад голлон чиглэж байгаа тул бэлтгэсэн асуултуудын хүрээнд анкет авах нь дүнг тооцоход эерэг нөлөөтэй гэж үзсэн болно.

Монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсонтой санал нэгдэж байгаа эсэх талаар судалгаанд хамрагдсан хүмүүсийн хариулсан байдлыг авч үзвэл нийт оролцогсдын 96,6 хувь нь тийм гасэн байна. "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэнд хийсэн мониторингийн судалгаагаар 2004 оны

**Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс**  
байдлаар дээрх хувь 88,9 хувь байсантай<sup>9</sup> харьцуулахад илүү нэмэгдсэн нь нэгийг бодогдуулахаас өөр аргагүй юм.

Тэр тусмаа дээд боловсролтой хүмүүсийн 96,9 хувь нь энэ талаар санал нийлж байгаа ажээ. Ажил эрхлэлтийн хувьд хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 96,3 хувь, хувийн хэвшилд ажиллагсдын 97,9 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсад бүгдээрээ буюу 100 хувь нь нийгэмд авилгал түгээмэл болжээ гэсэн нь эдгээр салбарт ажиллагсдад авилгал тохиолдох, түүнтэй холбоотой үр дагаварыг дээрх хүмүүс илүүтэй хүртдэг байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа юм.

Авиалгалыг өөгшүүлэгч хүчин зүйлсээс иргэдийн эрх, үүргээ ухамсарладаггүй байдал, хуулийн талаарх мэдээлэл хомс байдал ба төрийн зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний олон шатлалт механизм, түүнээс урган гарах хүнд сурталт тогтолцоо гэсэн хоёр үзүүлэлтийг сонгон авч харьцуулан үзье. Хүснэгт 4 ба хүснэгт 5-аас харахад иргэд өөрсдөө эрх үүргээ төдийлөн сайн мэддэггүй, хууль эрх зүйн ойлголт, мэдээлэл хомс байгаа нь авилгалыг газар авахад нөлөөлж байна гэдэгтэй судалгаанд оролцогсдын 79,5 хувь нь хүнд сурталт тогтоо нь авилгалыг өөгшүүлж байна гэдэгтэй 87,6 хувь нь тус тус санал нийлж байна.

Дээд боловсролтой хүмүүсийн 89,3 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсдын 96,4 хувь нь буюу бусад салбарын хүмүүсээс хамгийн олон нь хүнд сурталт тогтолцоотой нэг ёсондоо төр, төрийн байгууллага, түүний үйл ажиллагаатай асуудлыг илүү холбож авч үзэж байгаа юм. Энэ нь дээрх хүмүүсийн хувьд төрийн үйл ажиллагааг ойлгож, мэдээллийг хүлээн авч тэдгээрт өөрсдийн

<sup>9</sup> "Авиалгальт тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт (мониторингийн судалгаа), Улаанбаатар: Admon printing, 2004

**Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс**  
дун шинжилгээг хийдэгтэй холбоотой гэж болох юм. Харин тусгай дунд боловсролтой хүмүүсийн 82,1 хувь, хувийн хэвшилд ажиллагсдын 83,5 хувь нь авилгалыг иргэд өөрсдөө өөгшүүлж байна гэдэгтэй бусдаас илүү санал нийлжээ. Иргэд хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл хангалтгүй тэр хэрээр эрх, үүргээ тэр бүр ухамсарладаггүй байдал гол хүчин зүйл гэж үзэж байгаа нь дээрх хүмүүсийн хувьд энэ асуудлын талаар түлхүү анхаарч, санаа зовж байдгийн нэг илэрхийлэл юм.

Төрийн байгууллагад ажиллагсдын 14,7 хувь, дээд боловсролтой хүмүүсийн 14,2 хувь буюу бусдаас харьцангуй олонх нь авилгалыг өөгшүүлж буй нь иргэдийн мэдлэг, ухамсартай холбоогүй гэж хариулсан нь дээрх хүмүүсийн хувьд мэдээллийн хүртээмж хангалттай байдаг, энэ хэрээр тэд өөрсдийн эрх үүргэ бусдаас илүү мэддэг, ухамсарладаг болохыг харуулж байна. Тэгвэл бүрэн дунд боловсролтой хүмүүс бусдаас илүүтэйгээр төрийн зүгээс иргэдэд үйлчлэх үйлчилгээний шинж байдал авилгалыг дэмжиж байна гэж саналаа өгсөн. Харин сонирхолтой нь мөн л дээд боловсролтой хүмүүс бусдаас илүүтэйгээр энэ тал дээр санал нийлж байгаа явдал юм. Асуудлын учир шалтгааныг ул суурьтай 88% үзэж, хандах тал дээр дээд боловсролтой хүмүүс бусад оролцогдоосоо илүү хандаж байгаа нь зөвхөн дээрх хоёр үзүүлэлтийн дүнгээс харагдаж байгаа хэрэг биш юм.

Авиалгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгааныг судалгаанд оролцогсдын 27% нь "Хүмүүсийн ёс сууртахуун дорийтож, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд явсан"-аас, 26 % нь "Албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсон"-оос, мөн 26 % нь "Авиалгалыг илрүүлэх төрийн байгууллагууд авилгалд идэгдсэн"-ээс, 20% нь

"Авилгалын талаарх хууль эрх зүйн систем бэхжээгүй"-гээс, 1% нь бусад шалтгаанаас гэж үзсэн байгааг хүснэгт 6-аас харна уу (Дээрх асуудлын хувийн жинг Зураг 1-ээс харна уу).

Харин дээрх хариултууд нь нийт оролцогсдын дундаж үзүүлэлт бөгөөд нас, хүйс, ажил эрхлэлт, орлого зэрэг үзүүлэлтүүдээр дотор нь ялган авч үзвэл зарим асуудалд зөрөөтэй хандсан ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал "Хүмүүсийн ёс суртахуун доройтоож, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд автсан"-аас гэж эмэгтэйчүүдийн 30,5% нь үзсэн байхад эрэгтэйчүүдийн 23,4% нь ингэж дүгнэсэн байлаа (Хүснэгт 6.-г үз). Бусад асуултанд харьцаангуй ойролцоо хандсан хандлага ажиглагдаж байна.

Тэгвэл авилгалыг таслан зогсоохын тулд нэн даруй ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар судалгаанд оролцогсдын 89,3% нь "Авилгалыг таслан зогсоод чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх", 71,6% нь "Авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулж ажиллуулах", 74,6% нь "Олон нийтийн дунд сургалт, сурталчилгааг сайн хийх", 83,9% нь "Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм баталж, чанд сахиулах", 75,8% нь "Авилгал авдаг төдийгүй, өгдөг этгээдэд хүлээлгэх шийтгэл бий болгох" гэсэн хүчин зүйлүүдэд тус тус ач холбогдол өгсөн нь харагдаж байна (Хүснэгт 7a, 7b, 7c, 7d, 7e-г үз). Төслийн судалгааг хийх явцад УИХ-аас "Авлигын эсрэг хууль" батлагдан гарч хэрэгжиж эхлэн, Авилгалтай тэмцэх газар байгуулагдан, үйл ажиллагаагаа эхлэх гэж буй зэрэг нь авилгалыг таслан зогсоод хийх ёстой хамгийн чухал арга хэмжээ болсон гэдэг нь дээрх харьцуулалтаар батлагдаж байна. Одоо харин тус хууль болон АТГ-ын талаар олон нийтийн дунд таниулах сургалт, сурталчилгааг эрчимтэй болох шаардлагатай гэдгийг судалгааны дүн харуулж байна.

Санал асуулгын хүрээнд тавигдсан нэг чухал асуудал бол респондентуудын хувьд тохиолдсон авилгал авах, өгөх тохиолдуудын тандалт юм. Зураг 3-аас хараад танд авилгал өгөх, авах явдал тохиолдож байсан бол ямар байгууллагууд дээр тохиолдож байсан бэ гэсэн асуултанд дараахи байгууллагуудыг нэрлэсэн байна. Үүнд: Судалгаанд оролцогсдын 42,8 % нь "Эрүүл мэндийн байгууллага", 37,1% нь "Гаалийн байгууллага", 32 % нь "Боловсролын байгууллага", 28,4% нь "Хууль сахиулах байгууллагууд", 26,8% нь "Төрийн захиргааны байгууллага", 20,3% нь "Татварын байгууллага", 19,5% нь "Мэргэжлийн хяналтын байгууллага", 15,8 % нь "Банк санхүүгийн байгууллага" - ыг тус тус нэрлэсэн байна. Үүнийг дан ганц судалгаанд хариулагчдын өгсөн саналын хувиар тайлбарлах нь өнгөц хэрэг болно. Тухайлбал эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх давтамжыг банк санхүүгийн болон мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагатай адилтаж авч үзэхэд бэрхшээлтэй юм. Иймээс энэ асуудлыг чанарын судалгааны хэсэгт илүү дэлгэрүүлэн шинжилж үзэх болно. Тэгээд ч энэ асуулгын хувьд тоон судалгааны үр дүнгээс илүү сонирхолтой хариултууд фокус-группын ярилцлагын үеэр цөөнгүй гарч байсныг дурьдах нь зүйтэй юм.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар дараахи үнэлгээг өгчээ (Зураг 4-ийг үз). Үүнд судалгаанд оролцогсдын 37,3% нь "Авилгалтай тэмцэх сайн хууль байхгүй", 30,2% нь "Аль ч шатанд хуулийг дагаж мөрддөггүй", 25,6 % нь "Авилгалын хэргийг таслан шийдсэн практик байхгүй" байгаа явдал гэж үзсэн бол 6,9 % нь "Хэлж мэдэхгүй байна" гэжээ. Мөн л хуулийн ач холбогдол ямар их болохыг эндээс харж болно. Давтан өгүүлэхэд энэхүү төслийн үйл ажиллагаа "Авлигын эсрэг хууль"

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

батлагдан гарахаас өмнө эхэлсэнтэй холбоотойгоор респондентуудын хариулт хуулийн хүлээлт ямар их байсныг давхар нотолж байна.

Харин судалгаанд оролцогдоос авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхой салбаруудаар ялан тодорхойлсон хариултуудыг задлан авч үзье. Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 61,7 % нь "Авилгал өгч төрөөр хөөцөлдөж эдийн засгийн чадавхаа сайжруулдаг буруу тогтолцоо хэвшил болсон", 55,2 хувь нь "Улс төрийн өндөр албан тушаалд томилогдох", 38,3 % нь "Сонгуульд нэр дэвшихийн тулд намдаа өндөр албан татвар төлөх", 33,1 % нь "Мөнгө ба улс төр хэтэрхий хутгалдсан", 26,0 % нь "Улс төрийн намын санхүүжилтын механизм хуулиар нарийн зохицуулагдаагүй" зэргийг онцолжээ (Хүснэгт 8-ыг үз). Төрийн зарим албан тушаал авлигаар хэн нэгэнд хуваарилагддаг гэсэн нийгмийн сэтгэл зүйтэй хэвээр байгааг энэ асуудлын хувьд хамгийн өндөр хувийг эзлэж байгаа авилгал өгч байж өндөр албан тушаалд томилогддог гэж үзсэнээс харж болох юм.

Улс төрийн эрх мэдэл, албан тушаал, давуу байдал мөнгө, санхүү бизнесийн аливаа үйл ажиллагаатай салшгүй уялдаатай болж байгаа нь улс төр бохирдож, хээл хахууль, авилгал улам тархаж буйг илэрхийлж байна. Энэ асуудлаар ч судалгаанд оролцогсдын талаас илүү хувь нь санал нийлж байгааг дээрх дүн батлаж байна.

Зураг 7-оос харахад авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 29,6% нь "Иргэдийн орлогын тэгш бус байдал",

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

20,3% нь "Эдийн засаг дахь цөөнхийн монопольчпол", 20,2% нь Амьжиргааны чадавхи сул", 17,4% нь "Ажлын байрны эрэлт их", 11,0% нь "Тендерийн шудрага бус өрсөлдөөн", 1,4% нь "Хүний шунал хэтэрснээс" гэсэн хариултуудыг өгчээ. Эдийн засгийн хүчин зүйлсийн хувьд бүхэлдээ авилгалыг улам нэмэгдүүлэхэд тэдгээр нь ойролцоо нөлөө үзүүлж байгаа нь энэ дүнгээс харагдаж байна.

Гэхдээ энд хувь хүний хүчин зүйлийг хамгийн багаар холбож үзсэн нь сонирхолтой. Хувь хүний эд, мөнгөний сонирхол буюу шунал авилгал авахад бага нөлөөлдөг гэж шууд хэлж боломгүй. Хэдий судалгааны дүн энэ асуудлын хувийн жин дөнгөж 1,4 хувь байгааг харуулж байгаа ч авилгалд автагдсан гэж олон нийтийн ойлгодог нийгмийн болон төрийн үйлчилгээний салбарт өндөр албан тушаал хашдаг хүмүүсийн хувийн хүмүүжил, соёлын түвшин авилгалыг дэмжихэд нөлөөлөх зайлшгүй хүчин зүйл болох нь гарцаагүй.

Үүнийг авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаарх олон нийтийн санал бодолтой холbon авч үзэж болно. Судалгааны дүнгээс харахад оролцогсдын дийлэнх олонх нь буюу 60,4 % нь "Ёс суртахууны үүрэг хариуцлага супларсан"-тай авилгалын асуудал нэмэгдэж байгааг холбож ойлгож байгаа нь дээрх таамаглалыг баталж байна. Ёс суртахууны хүчин зүйлсийн бусад хэмжүүрийн хувьд респондентуудын 34,3 % нь "Хүний мөс нинжин сэтгэл алдарсан", 3,7 % нь "Хэтэрхий нэрэлхүү зантай", 1,6 % нь "Хүний шунал нэмэгдэж, гар харах өвчтэй болсон" зэрэгтэй авилгал ёсөн нэмэгдэж буйг хамаатуулж авч үзжээ (Хүснэгт 9-ийг үз). Хэдийгээр энд хүчин зүйлийн онцлогоос шалтгаалан хэмжүүрүүдийг ялгүй зүгийн гэж болох угсээр илэрхийлсэн боловч үр дүнгээс харахад

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс арга зүйн хувьд тайлбарлаж болох дүр төрх үүссэн нь харагдаж байна.

Хүний шунал, нэрэлхүү зан, гар харах, хүний мөс зэрэг ойлголтууд хүмүүсийн дунд ихэвчлэн мөнгөний асуудалтай холбоотой тавигддаг байна. Иймээс авилгал нэгэнт мөнгөнөөс тусад нь авч үзэх боломжгүй зүйл юм бол үүнийг дэмжихэд болон хориглоход ёс суртахууны олон хүчин зүйлийг нийгэм дэх энгийн үг хэллэгээр илэрхийлэх нь арга зүйн хувьд боломжтой юм.

Тэгвэл судалгаанд оролцогдоос авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхой салбаруудаар ялган тодорхойлсон хариултуудыг задлан авч үзье. Авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх эрх зүйн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 36,5% нь "Авилгалын хэрэгт холбогдсон хүмүүсийг зохих хууль тогтоомжоор шийтгэж, шудрага ёсыг нийгэмд хэвшүүлэх", 36,3% нь "Авилгалын хуулийг боловсронгуй болгож, хэрэгжилтэнд дээд зэргээр анхаарах", 26,4% нь "Авилгалын тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авилгалаас гарах сөрөг үр дагаврыг сайтар ойлгуулах" гэсэн санал дүгнэлтүүдийг өгсөн байна (Зураг 5-ыг үз).

Эрх зүйн болон улс төрийн хүчин зүйлс зарим талаар давхцаж буй нь улс төр, эрх зүй хоёрын холбоо хамаарлаас урган гарч байгаа хэрэг юм. Хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах онцгой эрх бүхий УИХ, түүний гишүүдийг зөвхөн хуульчид, эсвэл зөвхөн улс төрчид байх ёстой гэх нь утгагүй. Тэгвэл авилгалын хүчин зүйлсийг хооронд нь огт холбоогүйгээр төсөөлөх нь дээрхийн нэгэн адил бас л боломжгүй зүйл юм.

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Авилгалыг багасгах, хориглоход чиглэсэн улс төрийн чухал алхмуудаар дараахи зүйлсийг нэрлэжээ. Зураг 6-аас харахад судалгаанд оролцогсдын 45,4% нь "Улс төрчдийн орлогын мэдүүлгийг нийтэд нээлттэй болгох", 30,6% нь "Намд хандив өргөх замаар сонгуульд нэр дэвшдэг байдлыг өөрчлөх", 21,9% нь "Намын санхүүжилтын орчинг сайжруулахад чиглэсэн хуулийг гаргаж хэрэгжилтэд дээд зэргээр анхаарах", 2,0% нь "Төрийн албан хаагчдыг намын харьяалалгүй болгох" зэргийг нэрлэжээ. Орлогын мэдүүлгийн талаар нааштай алхмууд хийгдэж эхэлж байгаа нь сайшаалтай. Гэвч энэ нь улс төрчдийн хувьд ялангуяа УИХ-ын гишүүдийн хувьд авч үзвэл зайлшгүй шинжтэй бус харин боломжит, сонголтот шинжтэй байгаа нь авилгалаас ангид байх боломжгүй гэсэн ойлголт нийгэмд хүчтэй хэвээр байх гол хүчин зүйлийн нэг болж байгаа юм. Намын санхүүжилтийн зарчим, хэмжээ, хандив өргөх асуудал холбогдох хуулинд хэрхэн тусгагдсаныг баримт материалын шинжилгээний хэсэгт өмнө дурьдсан билээ. Агуулгын хувьд боломжийн хуультай орон болох нь харагдаж байгаа ч хэрэгжилтийн асуудал олон нийтийн хувьд хангартгүй хэвээрээ байгааг судалгааны дүнгийн энэхүү хувь хэмжээнүүд илчилж байна.

Зан заншил, ёс суртахууны асуудал нь авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх бас нэгэн чухал үзүүлэлт юм. Энэ асуудлыг авилгалыг хориглоход нөлөөлөх эдийн засгийн тодорхой шийдлүүдийн байдалтай холбон авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна (Зураг 8-ыг үз). Судалгаанд оролцогсдын 58,0 % нь "Хүн бүхэнд хүн ёсны эрхэмлэх болон цээрлэх ёсыг багаас нь төлөвшүүлэх", 44,4 % нь "Хүнээс их хүч хөдөлмөр, мэдлэг ухаан зарж байж олж авдаг нэр хүндийг өргөж явах", 44,5 % нь "Ёс суртахууны үндсэн зарчмуудыг аливаа үйл ажиллагаанд эрхэмлэл

Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс болгох", 38,3 % нь "Өөрийн зан байдлыг шүүн тунгаах, өөртөө хандах ёс суртахууны үнэлэлтийг дээшлүүлэх" зэрэг саналуудыг өгсөн байна.

Хувь хүний багын хүмүүжил, ёс суртахууны эрхэм байдлаа хадгалж чадах зориг, ухамсар авилгалыг болон ер нь аливаа гэмт үйлдлийг газар авахуулахгүй байх ёс суртахууны гол хүчин зүйл болдог байна. Сонгож авсан үзүүлэлтүүдийн ихэнх нь хоорондоо ойролцоо үр дүнг харуулсан байгаа нь сонирхолтой.

Мөн харьцуулан харах үүднээс авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлсийг Зураг 8.-д хамтад нь харуулсан. Эдийн засгийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 62,1% нь "Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах", 33,1% нь "Төсвийн зөв зохистой зарцуулалтыг бий болгох, хяналтыг сайжруулах", 27,4% нь "Эдийн засгийн шудрага ерсөлдөөнийг зах зээлд бий болгох", 23,7% нь "Татварын зөв, зохистой бодлого боловсруулах", 15,8% нь "Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх" гэсэн санал дүгнэлтүүдийг тус тус хийжээ.

Ерөнхийдөө эдийн засгийг либеральчлах нь авилгалын эсрэг гол хүчин зүйл гэдэг нь дээрхээс харагдана. Үүнийг чанарын судалгааны дүнгээр улам баталгаажуулсан. Авилгалын асуудлыг олон талаас нь авч үзэхэд олон нийтийн санаа бодлын маш олон сонирхолтой дүр зураг гарч ирэх болмжтойг тоон судалгааны дээрх үзүүлэлтүүд харуулж байна. Ингээд дараагийн хэсэгт фокус группын ярилцлагын аргаар хийсэн чанарын судалгааны дүнг авч үзье.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс Чанарын судалгааны анализ

### Судалгааны зохион байгуулалт, зорилго, арга зүй

Тоон судалгаанд бүрэн дунд боловсролтой, түүнээс дээш боловсролтой хүмүүс хамрагдсан бөгөөд 57 хувь нь дээд боловсролтой хүмүүс байгаа нь түүврийн чанарын үзүүлэлт юм. "Фокус групп"-ын судалгааг авилгалыг дэмждэг болон хориглодог хүчин зүйлсийг тодруулан гаргах, улмаар тоон судалгааны үр дүнтэй харьцуулан үзэж иргэдийн санаа бодлыг нарийвчлан гаргаж эдгээр үр дүнгүүдээ нэгтгэн анализ хийх зорилготой байсан билээ. Судалгааг стандартын дагуу бэлтгэлийг бүрэн хангаж, сайтар зохион байгуулалттай явуулснаар тавьсан зорилгодоо амжилттай хүрлээ.

Төслийн багийнхан 4 фокус бүлэгт хуваагдсан 32 хүн дээр судалгаа хийсэн бөгөөд судалгаанд хамрагдагсад нь оюутнууд, хөдөөгөөс хот руу шилжин ирэгсэд, амжиргааны түвшингээрээ нийгмийн дундаж давхаргынхан, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтнүүд гэсэн нийтлэг шинжүүдээрээ нэг нэг фокус бүлэг болгон зохион байгуулагдсан юм. Чанарын судалгаандаа үр дүнг зөв гаргаж чадахуйц нийгмийн давхаргынхныг хамруулах зорилго тавьж тусгайлан бэлтгэсэн сонгох асуултын дагуу оролцогчдоо түүвэрлэн авсан. Судалгааны багынхан авилгалыг дэмждэг болон хориглодог хүчин зүйлсийн талаар урьдчилан бэлтгэсэн удирдамж, асуултуудын хүрээнд фокус бүлгийн оролцогчидтой прилцлагаа зохион явуулсан болно.

СУДАЛГААНЫ САН

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Фокус-бүлгийн ярилцлагыг явуулахдаа албан ёсны бус, энгийн хэлбэрээр явуулж, тухайн ярилцлагаас судалгаанд хамаатай ямар нэг шинэ мэдээлэл үргэлжлэн гарагхүй болтол сонгосон бүлэг оролцогчдын дунд давтан явуулах арга зүйг баримтлан ажиллав. Фокус-бүлгийн ярилцлагыг төслийн багийн гишүүд ээлжлэн удирдаж явуулсан. Ингэхдээ багаараа хамтран урьдчилан бэлтгэсэн сэдвийн удирдамж, дарааллыг баримтлан, урьдчилан тогтоосон асуултуудыг ашигласан болно.

Судалгааны бүлэг асуултууд: үр дүн, бүлэглэл, шинжилгээ

Фокус группын дөрвөн удаагийн чанарын судалгаанд оролцогсдын санал бодлыг үндсэн долоон асуудлаар системчлэн нэгтгэн гаргалаа. Үүнд:

1. Авилгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй гол гол зүйлийн талаарх таны бодол юу вэ гэсэн асуултанд оролцогсод

- Шүүх өөрөө авилгалд идэгдсэнээс
- Авилгал өөрөө нууцлаг бөгөөд өөрөө авилгалыг дагуулдаг учраас
- Авилгал 2 талдаа хоёуланд нь ашигтай учраас
- Олон нийт авилгалын талаар тодорхой ойлголтгүй, мөн авилгалыг байх ёстой зүйл мэт ханддагаас
- Авилгалтай тэмцэх газар УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг төрийн өндөрлөгүүдтэй холбоотой байгуулагдаж байгаа үед юу ч илрэхгүй
- Авилгалтай тэмцэх газрыг иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтийн хяналт, төрөл бүрийн мэргэжлийн төлөөлөл зэргээс бүрдүүлэх шаардлагатай

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

зэргээс бүрдүүлэх шаардлагатай гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

Үүнээс:

- "Шүүх өөрөө авилгалд идэгдсэнээс" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 64,2 хувь,
- "Авилгал 2 талдаа хоёуланд нь ашигтай учраас" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 57,4 хувь,
- "Авилгалтай тэмцэх газрыг иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтийн хяналт, төрөл бүрийн мэргэжлийн төлөөлөл зэргээс бүрдүүлэх шаардлагатай" гэсэн саналыг судалгаанд оролцогсдын 55,6 хувь,
- "Авилгалтай тэмцэх газар УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг төрийн өндөрлөгүүдтэй холбоотой байгуулагдаж байгаа үед юу ч илрэхгүй" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 52,4 хувь,
- "Олон нийт авилгалын талаар тодорхой ойлголтгүй, мөн авилгалыг байх ёстой зүйл мэт ханддаж дассанаас" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 38,3 хувь,
- "Авилгал өөрөө нууцлаг бөгөөд өөрөө авилгалыг дагуулдаг учраас" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 22,41 хувь тус тус гаргасан нь давтамжийн хувьд жин дарж байсан бөгөөд харин бусад "хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг роль сүл байгаа", "цагдаагийн байгууллага маш муу ажилладаг", олон нийтийн дундах сургалт, сурталчилгааны ажил муу" зэрэг санал бодлуудын давтамж харьцангуй бага байлаа.

СУДАЛГААНЫ САН

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

2. Авиалгалыг багасгахад ач холбогдолтой хүчин зүйлсийн талаарх таны үнэлгээ ямар байна гэсэн асуултанд судалгаанд оролцогсод

- Төрийн дарамтыг багасгах
- Төрийн болон бизнесийн үйл ажиллагааг нээлттэй байлгах
- Төгс чөлөөт өрсөлдөөнийг бий болгох
- Аль ч шатанд хариуцлагын механизмыг бий болгох
- Лиценз, зөвшеөрөл олгох явдлыг авилгал болгохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх /тендерийг нээлттэй явуулах г.м./
- Манай улс дахь хөдөлмөрийн үнэлгээг /цалин, урамшууллыг/ нэмэгдүүлэх
- Авиалгал нийгмийн хөгжилд асар их хор хөнөөлтэйг хүмүүст багаас нь ойлгуулах гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

Үүнээс :

- "Төрийн болон бизнесийн үйл ажиллагааг нээлттэй байлгах" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 71,2 хувь,
- "Лиценз, зөвшеөрөл олгох явдлыг авилгал болгохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх /тендерийг нээлттэй явуулах г.м./" гэсэн санал дүгнэлтийг оролцогсдын 57,8 хувь,
- "Эдийн засаг, улс төрийн салбарт "төгс чөлөөт өрсөлдөөн"-ийг бий болгох" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 49,1 хувь,
- "Манай улс дахь оюуны болон аливаа хөдөлмөрийн үнэлгээг /цалин, урамшууллыг/ нэмэгдүүлэх" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 46,2 хувь,
- "Аль ч шатанд хариуцлагын механизмыг бий болгох" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 35,3 хувь,

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- "Төрийн дарамтыг багасгах" гэсэн санал дүгнэлтийг судалгаанд оролцогсдын 26,5 хувь,
- "Авиалгал нийгмийн хөгжилд асар их хор хөнөөлтэйг хүнд багаас нь ойлгуулах" гэсэн хариултыг судалгаанд оролцогсдын 20,8 хувь тус тус өгсөн нь үндсэн гол гол санал дүгнэлтүүд байлаа. Харин "олон нийтийн хэвлэл мэдээллийн албадын нэвтүүлгийн бодлогод тусгах" гэсэн саналыг 10,2 хувь нь гаргаж байсан бол "авилгалын хэрэг илрүүлэлтэнд иргэдийг эдийн засгийн аргаар татан оролцуулах" болон "улс төрийн болон төрийн албан тушаалтнуудад энэ чиглэлээр сургалт явуулах /ёс зүйн/ гэсэн санал бага давтамжтай байлаа.

3. Танд авилгал авч, өгөх явдал тохиолдож байсан бол эдгээр байгууллагуудын алинд нь вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогсод:

- Барилгын компаниуд газрын албанад болон стандарт, мэргэжлийн хяналтын газруудад авилгал өгөх нь түгээмэл үзэгдэл болсон,
- Гаалиар авилгал өгөхгүйгээр өнгөрч үзээгүй,
- 10 жилийн багш наарт дүн гүйж эцэг эхчүүд авилгал /бэлэг/ өгөх явдал элбэг,
- Газрын алба авилгалаар ажилладаг. Жишээ нь 25 айлын орон сууц барих гэж 30-40 саяыг "тусалсанд" өгч байсан,
- Хэсгийн эмчээс өгсүүлээд эмнэлгийн аль ч шатанд авилгалгүй байна гэсэн ойлголт огт байхгүй,
- Өмгөөлөгчдийн холбоонд байдаг. Хэн ашгаасаа их өгч чадсан нь их мөнгөтэй хэргийг хуваарилж авдаг,
- Цагдаагийн байгууллагад,

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- Аль ч эмнэлгийн төрөхөд одоо улам бүр дэлгэрсээр байгаа,
- БСШУЯ-ны сургалтын төрийн сангийнхан,
- 500.000 төг өгвөл СЭЗДС-д оруулж өгье гэж байсан,
- Хэлмэгдүүлэлтийн нөхөн олговорыг шүүгчид талыг нь өгвөл ямар ч материал дутуу байсан олгож өгнө гэж байсан зэрэг жишээг тус тус дурьджаа.

Ярилцлагын нэлээн сонирхолтой хэсэг энэ байлаа. Энэхүү асуултын хариулт нь хувь хүн тус бүрт тохиолдсон бодит баримтат жишээ байсан учир дурьдагдсан байгууллагууд төдийлөн давцаагүй. Гэвч Газрын алба 6 тохиолдлоор, Эмнэлгийн байгууллага 5 тохиолдлоор, Цагдаа, шүүх, өмгөөллийн байгууллага мөн 5 тохиолдлоор, Гаалийн алба 3 тохиолдлоор тус тус давхардаж гарч ирж байсан нь анхаарал татаж байна.

4. Авиалгалыг дэмжин дэлгэрүүлэхэд болон хориглоход нөлөөлж буй эрх зүйн ямар хүчин зүйлс байна гэж бодож байна вэ гэсэн асуултын дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эрх зүйн хүчин зүйлсийн талаар:

- Хүнд суртал их байгаа явдал
- Эдийн засагт төрийн оролцоо их байгаа явдал
- Төрийн албан хаагчид намын харьялалтай байгаа явдал
- Ерөнхийлөгч Авиалгалтай Тэмцэх Газрын даргыг томилж байгаа явдал
- Дүрэм журам зөвшөөрлүүдийг авиалгалын үүсгэвэр болгож буй явдал
- Авиалгалын эсрэг хуулинд олон нийтийн санаа бодлыг огт тусгаагүй

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- Төрийн байгууллага, хувийн байгууллагын зааг байхгүй болсон
- УИХ, Засгийн газрын бие даасан байдал, харилцан хяналт алдагдсан
- Төрийн үйлчилгээний олон шат дамжлага
- Хариуцлагыг төр, төрийн аль нэг институт хүлээхээр байж хэрхэвч болохгүй,
- Авиалгалтай тэмцэх байгууллагын санхүүжилтыг хаанаас хийх, уг байгууллага ажлаа хэнд хэрхэн тайлгахаа зэргийг хуулинд бодолцолгүй хийсэн нь серөг үр дагаварыг авчирна,
- Хуулийн мэдлэг нимгэн иргэд үргэлж бэлэн олз болоод байна зэргийг дурьдсан бол,

Авиалгалыг хориглоход нөлөөлж буй эрх зүйн хүчин зүйлсийн талаар:

- Төрийн, байгууллагын зэрэг олон хэрэгтэй хэрэггүй “нууц”-уудыг ил болгох
- Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг ил болгох
- Сэтгүүлчдэд мэдээллийг олж авах эрхийг чөлөөтэй болгох
- НҮБ-ын авиалгалын эсрэг конвенцид нэгдэх хэрэгтэй
- Авиалгалтай тэмцэх олон улсын байгууллагад нэгдэх хэрэгтэй,
- Авиалгалтай тэмцэх байгууллага санхүүжилтынхаа тодорхой хувийг илрүүлсэн хэргийнхээ /мөнгөнийхөө/ тодорхой хувийг урамшуулал болгон авдаг байхаар зохицуулж болох юм зэргийг дурьдсан байна.

СУДАЛГААНЫ САН

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Дээрх саналуудыг системчлэн нэгтгэж авч үзэхэд дараахи санал дүгнэлтүүд давхардаж буюу илүү ач холбогдолтой гэж тооцжээ.  
Үүнд:

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эрх зүйн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 38,7 хувь нь "Төрийн албан хаагчид намын харьялалтай байгаа явдал", 26,9 хувь нь "Дүрэм журам зөвшөөрлүүдийг авилгалын үүсгэвэр болгож буй явдал", 11,2 хувь нь "Иргэдийн хуулийн мэдлэг нимгэн учраас" гэсэн хүчин зүйлсийг тус тус тэмдэглэжээ. Харин авилгалыг хориглоход нөлөөлж буй эрх зүйн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 42,1 хувь нь "Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг ил болгох", 35,8 хувь нь "Сэтгүүлчдэд мэдээллийг олж авах эрхийг чөлөөтэй болгох", 29,1 хувь нь "Төрийн", "Байгууллагын" зэрэг шаардлагагүй олон "нууц"-уудыг ил болгох, 20,5 хувь нь "Авилгалтай тэмцэх байгууллага"-ыг төрөөс хараат бус байлгах" гэсэн санал дүгнэлтүүдэд илүү ач холбогдол ёгсөн байна. Бусад саналуудын хувьд давтагдсан байдал төдий л ажилгагдсангүй.

5. Авилгалыг өөгшүүлэхэд болон хориглоход нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийн талаарх таны санал, үнэлгээ ямар байна гэсэн асуултын дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийн талаар:

- Намдаа хандив өгч албан тушаал авдаг
- Улс төрийн намын хатуу гишүүнчлэл
- Улс төрчдөд хариуцлага тооцож чаддаггүй
- Нам мөнгө өгсөн хүнд нэр дэвших эрх өгдөг

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- Улс төртэй, улс төрийн намтай холбогдсон авилгалын хэрэг илэрдэггүй
- Төрийн удирдлагын босоо чиглэл
- Улс төрийн намын хандив, санхүүжилт авилгалыг өөгшүүлж байна,
- Сайд, дэд сайд гэх мэт бүх албан тушаалуудад мөнгө өгч дэвшиж байна,
- Нийгэм хэт улс төржчихөөд байна зэргийг дурьдсан бол,

авилгалыг хориглоход нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийн талаар:

- Олон намын тогтолцоо зерэг нөлөөтэй,
- Цаашид улс төрийн намд өгдөг хандивыг хязгаарлаж өгөх,
- Албан тушаалын томилгооны арга механизмыг эрс өөрчлөх
- Хөрөнгө орлогын мэдүүлгийг тодорхой болгох зэргийг дурьдсан байна.

Дээрхи саналуудыг нэгтгэн авч үзвэл дараахи санал дүгнэлтүүдэд илүү ач холбогдол ёгсөн нь харагдаж байна. Үүнд: Авилгалыг дэлгэрүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийн талаар: судалгаанд оролцогсдын 68,4 хувь нь улс төрийн намын хандив, санхүүжилтийн буруу тогтолцоо, 63,1 хувь нь Сонгуульд нэр дэвших, албан тушаалд дэвших буруу шалгуур, тогтолцоо, 47,4 хувь нь улс төрийн намын хатуу гишүүнчлэл гэсэн санал дүгнэлтүүдэд илүү ач холбогдол өгчээ. Харин авилгалыг хориглоход нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсод олон намын тогтолцоо зерэг нөлөө үзүүлж байна гэснээс өөр тодорхой зүйл дээр нэгдсэн санал дүгнэлт байгаагүй болгээд харин цаашид улс төрийн намд өгдөг хандивын хэмжээг

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

хязгаарлаж өгөх, ил тод болгох, хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргадаг болох, албан тушаалын томилгооны арга механизмыг эрс өөрчлөх зэрэг саналуудыг дэвшүүлсэн байлаа.

6. Авилгалыг дэлгэрүүлэхэд нөлөөлж буй болон хориглоход чиглэсэн **эдийн** засгийн ямар алхмууд манай оронд чухал гэж та үзэж байна вэ гэсэн асуултын дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй **эдийн** засгийн хүчин зүйлсийн талаар:

- Гадаадын зээл тусламж нээлттэй биш байна
- Импортын бараа гаалийн авилгалаас үүдэн үнэ өртөг нь үргэлж өсдөг,
- Иргэдийн гар дээр бэлэн мөнгө их байдаг явдал,
- Эдийн засаг нь улс төртэй хэт хутгалдчихаад байна,
- Өнөөдөр Монголд байгаа аль ч албан тушаалтын цалин хангамж дэндүү бага байна.
- Ерөөс Монголд аль ч хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлс, түүний дотор оюуны хөдөлмөрийн үнэлгээ хэтэрхий бага байгаа нь эдийн засаг нийгмийн хөгжилд ихээхэн хохирол учруулж байна,
- Хөрөнгө орлогын мэдээлэл ил тод болоогүй байна,
- Тендерийн мэдээллийг маш сул хийдэг,
- Авилгал далд эдийн засгийг бий болгож байна, судалгаагаар манай нийт эдийн засгийн 30 хувийг эзэлж байна зэрэг санал дүгнэлтүүдийг хийжээ.

Харин авилгалыг хориглоход чиглэгдсэн эдийн засгийн ямар ямар алхмууд Монголд чухал гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогсод дараахи хариултуудыг өгчээ. Үүнд:

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- Цаашид эдийн засгийг либеральчлах, ил тод болгох тусам авилгал багасах болно,
- Эдийн засгийг улс төрөөс ангид байлгах арга механизмыг бүрдүүлэх,
- Хөдөлмөрийн цалин хөлсний үнэлгээг эрс дээшлүүлэх,
- Иргэдийнхээ амьжиргааны төвшинг дээшлүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах,
- Далд эдийн засгийг зогсох, ядаж дорвитой багасгах,
- Авилгалын хэрэг илрүүлэхэд "эдийн засгийн арга"-ыг хэрэглэх,
- Үндэсний үйлдвэрлэлийн хөгжилд бага ч гэсэн найдвар тавьж байна гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

Дээрхи санал дүгнэлтүүд дээр анализ хийж үзвэл: авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 64,8 хувь нь "Монголд аль ч хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлс бага байгаа нь авилгалыг дэлгэрүүлэхэд нөлөөлж буй төдийгүй нийгмийн хөгжилд ихээхэн саад болж: байна", 55,2 хувь нь "Эдийн засаг улс төртэй хэт хутгалдчихаад байна", 43,6 хувь нь "Тендерийн мэдээллийг маш муу хийдэг", 37,8 хувь нь гадаадын зээл болон тусламжын талаархи мэдээлэл нээлттэй биш байна", 25,9 хувь нь "Авилгал далд эдийн засгийг бий болгож, далд эдийн засаг нь авилгалыг төрүүлж байна", 18,2 хувь нь иргэдийн гар дээр бэлэн мөнгө ихээхэн хэмжээгээр байдаг явдал авилгал, далд эдийн засгийг ногшүүлж байна" гэсэн хариултуудыг өгсөн.

Харин авилгалыг хориглоход чиглэгдсэн эдийн засгийн ямар ямар алхмууд Монголд чухал гэж үзэж байна вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 70,1 хувь нь "Эдийн засгийг

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

либералчлах", 66,3 хувь нь "Хөдөлмөрийн цалин хөлсний үнэлгээг эрс дээшлүүлэх", 53,6 хувь нь "Эдийн засгийн салбар дахь ил тод, нээттэй байдлыг эрс сайжруулах", 48,8 хувь нь "Эдийн засгийг улс төрөөс ангид байлгах арга механизмыг бүрдүүлэх", 34,1 хувь нь "Далд эдийн засгийг зогсоох, дорвитой багасгах", 30,6 хувь нь "Нийт иргэдийнхээ амьжирааны төвшинг дээшлүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах", 20,2 хувь нь "Авиалгалын хэрэг илрүүлэхэд "эдийн засгийн арга"-ыг хэрэглэх", 19,3 хувь нь "Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих" зэрэг санал дүгнэлтүүдэд тус тус ач холбогдол өгсөн нь харагдаж байна.

Эдийн засгийг либералчлахыг "Авиалгалтай тэмцэх үндэсний хөтөлөр"-ийн нэг чиглэл болгон авч үзсэн байдаг талаар баримт материалын анализ хийсэн хэсэгт өгүүлснийг сануулах нь зүйтэй юм.

7. Авиалгалыг дэмжин дэлгэрүүлэхэд болон хориглоход зан заншил, ёс суртахууны ямар хүчин зүйлс байна гэж бодож байна, вэ гэсэн асуултын дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар:

- Монголчууд эртнээсээ л авилгал авсаар, өгсөөр ирсэн нь нөлөөлж байна,
- Монголчуудын "бэлэг" өгөх дуртай зан нь авиалгалыг хүлээн зөвшөөрөхд нөлөөлсөн,
- Одоо ч хөдөө айлд төрийн тэргүүн очиход морь бэлэглэсээр байгаа,
- Монголчуудад ах дүүдээ, тэр ч бүү хэл хамаатан садандай тусалж байх ёстой гэсэн ойлголт их дэлгэрмэл байдаг нь нөлөөлдөг,

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

- "Танилын нүүр халуун" гэсэн хууль үйлчилсээр "танилын маф"-ыг үүсгэдэг,
- Манайд аль ч ажил төрлийг хөөцөлдөхөөсөө өмнө хариуцаж буй хүнийг нь сайн таних хүнийг хайж эхэлдэг зуршил тогтсон гэж болно
- Бид юм бүрийг ашиг сонирхлын үүднээс хэт хараад сурчихсан байна, ингэж нэг талын барьсан үзэл хандлага хүчтэй тогтсоноор "хариуцлагатай улс төр", "хариуцлагатай бизнес" зэрэг ойлголтууд амьдралд хэрэгжихгүй, зөвхөн хэлбэр төдий байна,
- Өнөөдөр эцэг, эхчүүдийн нилээн хэсэг нь үр хүүхэддээ "сэргэлэн" амьдрахгүй бол энэ нийгэмд амьдарч чадахгүй "гэж сургаж байна зэргийг дурьдсан бол авиалгалыг хориглоход нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар:
- Хүмүүсийн хариуцлагыг /ёс суртахууны зарчмыг/ дээшлүүлэх,
- Хүүхдийг ёсвөр үеэс нь л зөв хүмүүжүүлээгүй бол хожим ямар ч боловсролтой болсон ухамсар нь хэвээрээ л байна,
- Авиалгалын эсрэг ялангуяа иргэдийн ухамсарт нөлөөлөх талаар Ханс Зайделийн сангаас өөр ажил зохиож байгаа газар алга,
- Авиалгалын талаархи олон нийтийн дунд тархсан одоогийн бодол төсөөллийг өөрчлөх,
- Бюрократын ёс зүйг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэх,
- Нутаг усны үзэл хүчтэй хэвээр байгаа төдийгүй, түүнийг дэвэргэсэн олон арга хэмжээ авч явуулсаар байгаа нь сайн талтай ч саар талтайг мартаж болохгүй,
- Ёс зүйн зохицуулалт нь эдийн засгийн, эрх зүйн хүчин зүйлсийн зохицуулалтгүйгээр төдийлөн үр дүнгээ өгөхгүй зэрэг санал дүгнэлтүүдийг тус тус хийжээ.

Дээрхи санал дүгнэлтүүдийг нэгтгэн авч үзвэл авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар: судалгаанд оролцогсдын 48,3 хувь нь "Манайд аль ч ажлыг танил талаараа хөөцөлдөж байж бүтдэг болсон явдал", 37,4 хувь нь "Бэлэг", "Авиалыг" хоёрыг зааглаж чадахгүй, хүсэхгүй байгаа явдал", 21,1 хувь нь "гар цайлгах, нөгөө талаас "гар харах" гэсэн өмнөх үеэс өвлөж ирсэн ёс заншил нь орчин үед "ашиг сонирхол" гэсэн хүчтэй зүйлтэй нэгдсэнээс өнөөдөр ёс зүйн зохицуулалтын роль эрс багасаж байна" 15,8 хувь нь "Өнөөдөр эцэг, эхчүүдийн нилээн хэсэг нь үр хүүхэддээ "сэргэлэн" амьдрахгүй бол энэ нийгэмд амьдарч чадахгүй "гэж сургаж байна гэсэн санал дүгнэлтүүдэд илүү түлхүү анхаарал хандуулсан бол авилгалыг хориглоход нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 52,4 хувь нь "Авиалын талаархи олон нийтийн дунд тархсан одоогийн бодол "тесөөллийг өөрчлөх", 42,5 хувь нь "Хүмүүсийн хариуцлагыг /ёс суртахууны зарчмыг/ дээшлүүлэх", 41,9 хувь нь "Ёс зүйн зохицуулалт нь эдийн засгийн, эрх зүйн хүчин зүйлсийн зохицуулалтгүйгээр төдийлөн үр дүнгээ өгөхгүй", 22,1 хувь нь "Хүүхдийг өсвөр үеэс нь зөв ойлголттойгоор хүмүүжүүлэх" гэсэн санал дүгнэлтүүдийг тус тус хийжээ.

Чанарын судалгаанд хамрагдагсад УИХ-ын гишүүдээс авахуулаад жирийн хүмүүс хүртэл нутаг усныхан гэх үзэл, танилын нүүр халуун гэсэн тогтсон заншил нь авилгал бий болоход нөлөөлж байна. Бие биедээ тус дэм болж амьдардаг нүүдэлчин аж төрөх ёс, хамаатан садан, ах дүүсээ өөд нь татаж, дэмжиж тусладаг ёс заншил нь орчин үед авилгал болон хөгжлөө. Социализмын үед хаалттай байсан авилгалын асуудал энэ байдлаас гэнэт

сулармагц харгис ширүүн шинжтэйгээр хүчтэй газар авлаа гэсэн хариултуудыг өгчээ. Шашны зан үйл, номлолоор л авилгалыг хумъж магадгүй өөрөөр энэ нь маш хэцүү асуудал гэсэн сонин хариултуудыг ч өгсөн байлаа.

Чанарын судалгаанд оролцож хариулт өгсөн байдал нь нэг хүн биш хэд хэдэн хүний санаа бодлыг тусгаж байгаа тул зарим тохиолдолд бие биенээ үгүйсгэсэн шинжтэй хариултууд орж ирснийг анхаарахыг хэрэгтэй болов уу.

Судалгааны дүнгээс харахад олон түмэн авилгалтай тэмцэх ажлыг илүү оновчтой үр дүнтэй болоосой гэж хүсч явдаг нь харагдаж байна. Түүнчлэн төр засгийн аль ч шатны үйл ажиллагаа, гарч байгаа шийдвэр нь ил тод, нээлттэй байвал авилгалыг бууруулахад чухал хүчин зүйл болно гэдэгт итгэж байгаа нь илт байна. Эцэст нь тэмдэглэхэд, бидний явуулсан судалгаа нь аль нэг нам, улс төрийн хүчний захиалга, даалгавараар хийгдээгүй цэвэр судалгааны шинжтэй байгаа гэдгээ илэрхийлэхийг хүсч байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Авиалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс  
Тоон болон чанарын судалгааны харьцуулалт,  
нэгдсэн анализ

Нийгмийн өөрчлөлт шинэчлэлт эхэлсэн үеэс хойших Монголд авилгал, хээл хахууль улсын өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьчлал, улмаар газрыг хувьчлах үйл явцад илрэх болжээ. Өнөөгийн нөхцөлд банк, уул уурхайн салбар авилгал үүсэн гарах боломжтой салбаруудад тооцогдож байгаа бол, шүүх ба хууль эрх зүйн салбар, гааль, тендерийн асуудал өндөр эрсдэлтэйд тооцогдоор байна. Ийнхүү эрсдэлтэй хэсгийг салбаруудаар нь тооцон гаргахаас гадна төвшингөөр нь ялган зааглаж авч үзэх нь арга зүйн хувьд илүү оновчтой юм. Үүнд судалгааны баг авилгал, түүнийг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийг судлахдаа дээд төвшний болон дунд шатны буюу өөрөөр хэлбэл улс төрийн төвшний болон захиргааны төвшний гэж ялган зааглаж авч үзсэн болно. Монгол улсын хувьд захиргааны болоод улс төрийн төвшний аль алинд нь байгаа авилгач байдлыг хазаарлах талаар үр ашигтай арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай байна.

Монгол дахь дээд төвшний авилгал илүү "аюултай" бөгөөд илүү "боловсронгуй" болж байгаа нь судалгаануудад давхардан тэмдэглэгдсэн байна. Энд "төрийг барьцаалах" гэсэн нэр томьёо ч гарч ирсэн байна. Улс төрийн төвшин дэх авилгалыг сааруулах, таслан зогсоох явдал ганц "Авиалын эсрэг хууль" – иар хязгаарлагдахгүй бөгөөд төрийн эрх мэдлийг хуваарилах, улс төрийн институтуудын харилцааг зохицуулах олон хуулиудад тусгалаа олж байж хэрэгжих юм. Сонгуулийн кампанийн санхүүжилт, улс төрийн намуудын санхүүжилт, улс төрийн албан

Авиалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс тушаалуудын томилгоо зэрэг нь өнөөдөр улс төрийн төвшний авилалыг өөгшүүлэгч гол хүчин зүйлийн нэг болж байгааг тоон болон чанарын судалгааны дүн харуулж байна. Энэ нь эдгээрийг зохицуулж буй хууль, тогтоомжууд улс төрийн төвшин дэх авилалыг сааруулах, таслан зогсооход шаардлага хангахгүй байгаагийн илрэл юм.

Чанарын судалгаанд оролцогдоос нэг ч хүн монголын өнөөгийн нийгэмд авилга байхгүй гэж үзээгүй байна. Тоон судалгаанд нийт оролцогчдын 96,6% нь ийм саналтай байсантай харьцуулахад өндөр хувьтай гарчээ. Чанарын судалгаанд оролцогчид нь тоон судалгаанд хамрагдагсадаас хэт цөөн байгаа нь ийм өндөр хувьтай гарахад нөлөөлсөн байгаа. Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна. Чанарын судалгаанд оролцогсод нь саналаа чөлөөтэй илэрхийлж ярилцаж байгаа учраас хэн нэгнийхээ ярьсан зүйлийг давхардуулж ярихгүй гэсэн тал их ажиглагдаж байгаа тул тэдний санаа бодлыг процентаар илэрхийлэх боломжгүй. Харин зарим тохиолдолд нэгнийхээ эсрэг байр суурьтай байгаа тохиолдолд түүнийг тусгайлан анхаарч судалгааны дүгнэлт, бөвлөмжийн хэсэгт тусгасан болно.

Чанарын судалгаанд оролцогчид эхний асуулт болох авилалын хэргийг илрүүлэхэд саад болж буй гол гол зүйлсийг тодорхойлсон байдлыг авч үзье. Улс төрийн өндөр албан тушаалтууд бие биетэйгээ авилгалын сүлжээгээр холбогдчихсон. Хэн нэг нь асуудалд орлоо гэхэд бие биенийгээ хамгаалчихдаг, том улс төрийд хамгаалдаг тул шийтгэгдлээ гэхэд суллагдах, өршөөгдөх магадлал өндөр, хуулийн заалтууд нь авилга өгсөн, авсан, зуучилсан бүгдийг нь шийтгэдэг учраас илрэх боломжгүй болгодог.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Улс төр нь мөнгтэй хэт их хутгалдсан, шүүх цагдаагийн байгууллага ч улс төрчидтэй холбоотой, авилгалын хэргийг нуун дарагдуулах тал руугаа их үйл ажиллагаа явуулдаг. Шүүх цагдаагийн байгууллага нь өөрөө авилгалд идэгдчихсэн. Бүх хүн өгөх, авах сэтгэлгээтэй болчихсон, хүмүүс өөрийн ажил нь бүтэж байгаа тул авилга өгч байна гэж сэтгэл нь зовдогтүй. Албаны бюрократ бүтэц нь өөрөө ийм байдал руу түлхэж байна гэж хариулжээ. Чихэрийн набор, вино гэх мэт зүйл нь авилга мөн үү гэдгийг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй гэж үзсэн байна.

Авилгалын хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгаанууд гэсэн дээрхи асуултанд тоон судалгаанд оролцогсад дараах байдлаар хариулт өгсөн юм. Үүнд: Албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсноос гэж нийт оролцогчдын 26.4%, авилгалыг илрүүлэх төрийн байгууллагууд нь авилгалд идэгдсэнээс гэж 25.6%, Авилгалын талаархи хууль, эрх зүйн систем бэхжээгүй гэж 20.1%, хүмүүсийн ёс суртахуун доройтох, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд автсан гэж 27.0% бусад шалтгаанаар гэж 1% нь хариулсан байв.

Чанарын болон тоон судалгааг харьцуулан авч үзвэл аль аль судалгаа нь авилгалын илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгааныг адилхан харуулжээ. Харин чанарын судалгаанд тоон судалгаанд гарч ирээгүй албан тушаалтнуудын хоорондын сүлжээгээр холбогдсон байдал, хэн нэг нь шийтгэгдлээ гэхэд түүнийг нь хамтаараа нуун далдах, шийтгэлийг нь хөнгөрүүлэх, үгүйсгэх арга барилтай болсон явдал авилгалын хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлдөг томоохон шалтгаан гэж үзжээ.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Судалгаанд оролцогдоос авилгалыг алга болгоход нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ямар санаа бодолтой байгааг асуусан юм. Тоон судалгаанд хамрагдагсадын 46.2% нь авилгал авдаг болон өгч буй этгээдэд хүлээлгэх шийтгэлийг бий болгох явдал маш их ач холбогдолтой, 29.6% нь ач холбогдолтой гэж үзсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж сахиулахыг маш их ач холбогдолтой гэж 47.7%, ач холбогдолтой гэж 36.3%, олон нийтийн талаар энэ талын сурталчилгаа хийхийг маш их ач холбогдолтой гэж 41.2%, ач холбогдолтой гэж 33.5%, Авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулж ажиллуулахыг маш их ач холбогдолтой гэж 35.7%, ач холбогдолтой гэж 35.9% үзжээ. Тоон судалгаанд оролцогчдын хамгийн их ач холбогдол өгсөн зүйл нь авилгалыг зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх явдал гэсэн байлаа. Нийт оролцогчын 61.5% нь энэ арга хэмжээг маш их ач холбогдолтой гэж, 27.8% нь ач холбогдолтой гэж үнэлсэн байгаа нь нийт оролцогчын 89.3% болж байна.

Тэгвэл энэ асуудлыг чанарын судалгаанд оролцогчид хэрхэн авч үзсэнийг харьцуулан үзье. Чанарын судалгаанд хамрагдагсад хамгийн их анхаарал тавьсан, авилгалыг арилгахад нөлөөлөх чухал ач холбогдолтой гэж тооцсон зүйл нь шийтгэлийг хатуу болгох, гэхдээ өгсөн авсан хоёуланг нь биш харин авсныг нь хатуу шийтгэдэг хуультай болох явдал гэж үзсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж мөрдүүлэх гэсэн тоон судалгааны дүнтэй нилээд дөхж очихуйц санал болох бюрократуудын сэтгэлгээг өөрчлөх явдал чухал гэж үзжээ. Гэхдээ энэ санал төдийлөн их давтагдахгүй байгаа, мөн ийм дүрэм батлан гаргах хэрэгтэй гэж дурдахгүй байгаа нь чанарын судалгаанд хамрагдагсад энэ зүйлд нэг их ач холбогдол өгөхгүй байгааг каруулж байна. Харин ч эсрэгээрээ дээд түвшинд байгаа

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

авилгалыг бид нэгэнт арилгаж чадахаасаа өнгөрсөн, арилгахад их хэцүү гэж гутарсан санал нилээд цухалзаж байлаа.

Чанарын судалгаанд оролцогчид төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх нь төдийлөн үр дүнд хүргэхгүй, харин ч орлого нэмэгдэхийн хэрээр тансаг хэрэглээ нэмэгдэх тул энэ нь авилгалыг арилгах хүчин зүйл болж чадахгүй гэж үзэж байна. Одоо манай төр, засгаас чухал ач холбогдол өгч байгуулж байгаа авилгалтай тэмцэх байгууллага хэр зэрэг ач холбогдолтой байх талаар санал асуухад тоон судалгаанд хамрагдагсад маш их ач холбогдолтой гэсэн хариулт дээр хамгийн цөөн санал өгч байсан бол чанарын судалгаанд хамрагдагсад хэрэв ийм байгууллага байгуулах болвол иргэний төлөөлөл маягаар л зохион байгуулбал үр дүнд хүрч магадгүй, харин ямар нэг эрх мэдэл бүхий субъект томилдог байвал дахин нэг авилгал авдаг байгууллага л нэмэгдэнэ шүү дээ гэсэн санал гаргаж байлаа. Тэгэхээр хоёр судалгаа хоёулаа энэ арга хэрэгслэлийн үр дүнд эргэлзэж байгаа нь харагдаж байна. Чанарын судалгаанд хамрагдагсад төрийн албандаа чадвар муутай хүмүүс их шурагладагаас эдгээр хүмүүс мөнгө олох аргаа болгож авилгалын цэцэглүүлж байна гэж үзжээ.

Хүмүүсийн дунд явуулах сургалт, сурталчилгааны ажил болон багаас нь авилгалгүй амьдараахаар хүмүүжүүлэх нь тодорхой үр дүнд хүргэж болно гэж үзэж байна. Гэхдээ чанарын судалгаанд оролцогчид авилгалын эсрэг хатуу хууль гаргаж, хуулиа хэрэгжүүлж хатуу шийтгэл хүлээлгэх замыг л аль ч арга хэрэгслэлээс чухалчилж байна. Бусад зүйлсийг энэ арга замд хавсарга маягаар л хэрэглэх гэсэн байдлаар хандаж байлаа.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Ямар байгууллагад авилга авах, өгөх явдал их байна, түүний учир шалтгаан юунд байна гэдгийг тодруулья. Судалгаанд оролцогчдоос танд болон танай ойр дотныхон хэй нэг албан тушаалтанд авилгал өгөх, эсвэл авах тохиолдол гарч байв уу гэсэн асуулт тавьсан юм. Тоон судалгаанд хамрагдагсадын хувьд нэрлэсэн байгууллагуудаар ангилан гаргаснаас хамгийн их хувийг эрүүл мэндийн болон гаалийн байгууллагад тохиолдож байсан гэсэн хариулт эзлэж байсан (Зураг 3-ыг үз).

Тоон судалгаанд хамрагдагсадын 42.8% нь эрүүл мэндийн салбарт, 37.1% нь гаалийн байгууллагад, 32.0% нь боловсролын байгууллагад, 28.4% нь хууль сахиулах байгууллагад, 26.8 хувь нь төрийн захиргааны байгууллагад, 20.3% нь татварын байгууллагад, 19.5% нь мэргэжлийн хяналтын байгууллагад, 15.8% нь банк, санхүүгийн байгууллагад ажиллагсадад хахууль өгч байсан гэж хариулсан бол чанарын судалгаанд хамрагдагсад бараг бүгдээрээ өөрөө болон ойр дотныхон нь авилгал өгөх зайлшгүй хэрэгцээ гарсан гэж хариулжээ. Хэрвээ бид өнгөхөн харах юм бол Эрүүл мэнд, боловсролын салбарт авилга өгөх явдал хамгийн их харагдаж байгаа юм. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа нь айл бүрийн бараг өдөр тутмын гэж хэлж болохуйц амьдралтай илүү ойр байдаг, бараг хүн бүрт хүртээлтэй байдаг онцлогыг харгалзаж үзэх юм бол энэ байгууллагуудыг ийм олон хүн цохиж хэлэх нь гарцаагүй. Гэтэл хил гааль давж явдаг хүмүүс нийт хүн амтай харьцуулахад хэр зэрэг өндөр хувьтай вэ, тэдгээр дотроо гаалиар татвартай бараа оруулж ирэх хүний тоо хэд билээ гэж тооцоод анхаарч үзэх юм бол нийт оролцгосдын 37.1% нь хахууль өгч үзсэн гэж хэлж байгаа гаалийн салбар бол хамгийн өндөр үзүүлэлттэйгээр авилгалд идэгдсэн байгууллага болж байна. Гэхдээ боловсролын байгууллагад сургуульд орох,

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

хуурамч бичиг баримт бүрдүүлэх, багш нарт тал засах гэх мэтээр, эрүүл мэндийн салбарт эмч, сувилагч нараас байх ёстой хэм хэмжээнийх нь чанартай үйлчилгээг авахын төлөө өгч байгаа а빌гал нь тооны олноор хүмүүсийн амьжиргаа, сэтгэлгээнд ихээхэн хохирол учруулж байгааг үгүйсгэхгүй байна. Мөн хууль сахиулах байгууллагаад хахууль өгөх шаардлага гарах хүмүүсийн тоо нийт хүн амтай харьцуулахад бага мөртлөө судалгаанд оролцогодын 28.4% нь энэ салбарынханд аビルгал өгсөн гэж үзэж байгаа нь бас л энэ байгууллага маш их аビルгальд идэгдсэн болохыг харуулж байна. Мэргэжлийн хяналт болон татварын байгууллагынхан бас л яг иймэрхүү нөхцөл байдалтай байгаа нь эргэлзээгүй.

Фокус-группын ярилцлагын онцлог, уур амьсгалаас шалтгаалан оролцогчид санал бодол, мэдээллээ харамгүй хуваалцсан гэж ойлгож болно. Үндсэндээ чанарын судалгаанд хамрагдагсад бараг бүгдээрээ өөрөө болон ойр дотнынхон нь аビルгал өгөх зайлшгүй хэрэгцээ гарсан гэж хариулжээ. Ямар нэг зөвшөөрөл авах гэж, тендэрт ялах гэж, эмч сувилагч нараас сайн үйлчилгээ авахын тулд, цагдаа нарын дарамтаас гарахын тулд, сургуульд орохын тулд гэх мэтчилэн маш олон хэлбэрээр аビルгал өгч байсан гэжээ. Тэднийхээр цаг алдаж, бөөн түвэгээс нь залхаж, бюрократуудын хүнд суртлаас нь болоод ийм аргыг аргагүйн эрхэнд сонгосон гэж үзэж байна. Тэгэхээр судалгаанд оролцогод монголын нийгэмд аビルгал маш их түгээмэл үзэгдэл болсон гэдгийг зүгээр нэг баримжаагаар хэлсэн хэрэг биш өөрсдийн амьдралд тохиолдож байгаа бэрхшээлтэй байдлыг давах хамгийн хялбар арга болгон энэ замыг сонгох болсон гэдгийг бодитой баримтанд тулгуурлан хэлсэн хэрэг байлаа гэж үзэж болох юм.

## Авиалгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Судалгаанд хамрагдагсад аビルгалыг хориглоход нэлөөлөх эрх зүйн хүчин зүйлийг хэрхэн авч үзэж байгааг харьцуулан үзье.

Тоон судалгаанд хамрагдагсад энэ асуултанд 36.5% нь аビルгалын хэрэгт холбогдсон хүмүүсийг зохих хууль тогтоомжоор шийтгэж, шударга ёсыг нийгэмд хэвшүүлэх, 36.3% нь аビルгалын хуулийг боловсронгуй болгож, хэрэгжилтэнд дээд зэргээр анхаарах, 26.4% нь аビルгалын тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, аビルгалаас гарах сөрөг үр дагаварыг сайтар ойлгуулах гэж хариулжээ.

Чанарын судалгаанд хамрагдагсад аビルгалын эсрэг хуулийн заалт нь өөрөө буруу байна. Авсан өгсөн хоёуланг нь шийтгэдэг нь аビルгалыг илрүүлэх бололцоо олгохгүй байна. Аビルгальтай тэмцэх байгууллагын удирдлагыг ард түмнээсээ сонгох эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Чухам юуг аビルгал гэх вэ гэдэг хуулийн заалтаа боловсронгуй болгох хэрэгтэй. Чихэрийн цуглувалга, вино гэх мэт жижиг зүйлийг яриад цаана нь байгаа маш том аビルгалын асуудал сүүдэрт нь үлдээд байна. Хэтэрхий их дүрэм журам батлаж нэг байгууллагад хэтэрхий олон янзын хяналт тавьдаг нь дахиад л аビルгалын нэг үндэс суурь болоод байна. Зах зээлийн харилцаа нь өөрийн жам ёсоороо хөгжвэл аビルгал алга болох ёстой. Төр юм бүхэнд оролцоод байгаа нь аビルгалыг алга болгоно шүү дээ гэсэн байна.

Чанарын болон тоон судалгаанд хамрагдагсад аль аль нь аビルгалын эсрэг хуулийн заалтууд дутагдалтай байгаа гэж үзэж түүнийг боловсронгуй болгох хэрэгтэй гэжээ. Аビルгалын эсрэг хуулийг иргэдэд сурталчлах гэдэг дээр тоон судалгаанд хамрагдагсад бусад асуултуудтай харьцуулахад хамгийн бага

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

санал өгсөн бол чанарын судалгаанд хамрагдагсад үүнтэй ойролцоо хариултыг зөвхөн ганц хүн л хэлжээ. Тэгэхээр хоёр судалгаа аль аль нь иргэд хуулиа мэддэг байх нь төдийлэн үр дүнд хүргэхгүй. Хяналт, зөвшөөрлийн олон шаттай тогтолцоо хүмүүсийг авилгал руу түлхээд байна. Хуулийн заалтаяа авилгал авагсад руу илүү чиглүүлээч гэж үзээд байгаа тал харагдаж байна.

Авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлийг иргэд юу гэж үзэж байгааг одоо авч үзье. Тоон судалгаанд хамрагдагсадын 61.7% нь авилгал өгч улс төрийн өндөр албан тушаалд томилогдох, 55.2% нь улс төрөөр хөөцөлдөж эдийн засгийн чадавхияа сайжруулдаг буруу тогтолцоо хэвшил болсон, 38.3% нь сонгуульд нэр дэвшихийн тулд намд өндөр албан татвар төлөх, 33.1% нь мөнгө ба улс төр хэтэрхий хутгалдсан, 26.0% нь улс төрийн намын санхүүжилтийн механизмыг хуулиар нарийн зохицуулагдаагүй гэсэн хариулт өгчээ. Бидний явуулсан энэхүү тоон судалгаагаар 4-өөс дээш сонгож бөглөх асуултан дээр хамгийн их хувиар санал нэгдэж байгаа хариулт нь эхний хоёр тоон үзүүлэлт болж байна. Тэгэхээр иргэд маань авилгал гэдэг зүйлийг хамгийн их өөгшүүлдэг хүчин зүйлд улс төрийн хүчин зүйлийг л оруулж ирж байна.

Чанарын судалгаанд оролцогсод дээрхи асуултанд хариулахдаа улс төрчдийн дунд маш том сүлжээ байна. Тиймээс илрүүлэлт маш бүрхэг. Улс төрийн намын санхүүжилт буруу, иймээс намд хандив нэрээр авилга өгч байна. Намын удирдлага, Засгийн Газрыг бүрдүүлэх гэх мэт томоохон халаа сэлгээ нь авилгалтай холбоотой. Улс төрчид сонгуульд орохын тулд хандив өгөөд дараа нь шархаа нөхөж байна. Нам ямар хүнийг ямар албан тушаалд тавихаа мэддэг. Ашигтай байр суурь эзлэхийн тулд уралдаан болж

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

байна. Энэ хуваарилалт нь өөрөө авилга бий болгодог. Жинхэнэ шилдэг хүмүүс цаана нь үлдээд хоцорч байна гэсэн хариултуудыг өгчээ.

Түүнчлэн, улс төрчдийн дунд ашигтай байр суурийн төлөөх тэмцэл болж байна. Түүнийг илрүүлэх боломжгүй, илрүүлэлт ч бүрхэг, улс төрчид төрийн өндөр албан тушаалыг эдийн засгийн гаргасан зардлаа нехөх арга хэрэгслэл болж байна гэж үзэж байна.

Тоон болон чанарын судалгаанд хамрагдагсад маш их ойролцоо хариулт өгсөн нь тодорхой харагдаж байна. Улс төрийн хүрээнийхний албан тушаалын төлөөх өрсөлдөөн, өндөр албан тушаалаар дамжуулж эдийн засгийн чадавхияа дээшлүүлэх гэсэн санаархал, улс төрийн намын үйл ажиллагаагаа явуулах механизм гишүүнчлэл зэрэг нь нийгмийн аль ч хэсгийнхэнд хамгийн их ойлгомжтой авилгалын сүлжээ үүсгэсэн гэж нийт судалгаанд оролцогсод үзсэн байна. Чанарын судалгаанд үүнийг угүйсгэсэн, өөр хувилбар гаргасан нэг ч санал гараагүй байна.

Үнэхээр манай улсад гарч байсан эдийн засгийн томоохон Хэргүүдэд улс төрчдийн нэр байнга холбогддог. Жишээлбэл, Алт дилиерийн хэрэг, 20-р тогтоолын нууцыг задруулсан хэрэг, Айбекс бүлэг, Молам корпорацитай байгуулсан гэрээний асуудал, Их дэлгүүрийн хувьчлал, Эрдэнэт концерний асуудал, нилээд хэдэн удаа давтагдсан их хэмжээний архи, спиртийн хэрэг, Төв Ази болон Худалдаа Хөгжлийн банкны асуудал гэх мэт нийгмийг доргиосон томоохон хэргүүдэд орооцолдож нэр нь дуулдаж байсан улс төрчидөөс хэн нь ч улс төрөөс зайлцуулагдсангүй. Харин ч улс төрийн карьер нь ахиж, төрийн өндөр алба хаших болжээ. Энэ бүхэн улс төр, хууль хяналтын байгууллага хоёр хоорондоо маш

нарийн холбоо сүлбээтэй, бие биенээ хаацайлдаг болсныг харуулдаг. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт "...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалт нь энэхүү хуулийн 49-р зүйлийн 1 дэх хэсэгт байх "Шүүгч нь хараат бус байж, гагчхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг биелүүлж байж л нийгэмд шударга ёсыг тогтоож чадах юм. Гэтэл сүүлчин заалт нь биелэгдэхгүй байгаа учраас эхний заалт нь гэм буруутан, авилгачидыг хаацайлах хууль эрх зүйн орчин болж хувираад байна<sup>10</sup>.

Судалгаанд хамрагдагсадаас авилгалыг хориглоход чиглэсэн улс төрийн хамгийн чухал алхамуудад улс төрчдын орлогын мэдүүлгийг нийтэд нээлттэй болгох гэдэгт 45.4%, нам хандив өгөх замаар сонгуульд нэр дэвшдэг байдлыг өөрчлөх нь чухал гэж 30.6% нь үзжээ.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлсийг тоон судалгаанд хамрагдагсад дараах байдлаар нэрлэсэн байна. Иргэдийн орлогын тэгш бус байдал гэж нийт оролцогсодын 29.6%, эдийн засаг дахь цөөнхий монопольчлол болон амжиргааны чадавхи сул гэж тус бүр 20.3%, ажлын байрны эрэлт их гэж 17.4%, тендэрийн шударга бус өрсөлдөөн гэж 11%, хүний шунал хэтэрсний улмаас гэж 1.4% ньтус тус санал өгчээ. Тоон судалгаанд хамрагдагсад өмнө гарч байсан асуултуудад маш их өндөр хувьтайгаар хариулт өгч байсан нь энэ асуултын хариултанд харагдахгүй байгаа нь авилгал бий болгоод байгаа эдийн засгийн хүчин зүйлүүд дээр харьцангуйгаар өөр өөр байр суурьтай байгааг харуулж байна.

<sup>10</sup> Үндсэн хуулийн дурдсан заалтуудыг харна уу.

Чанарын болон тоон судалгааны үр дүн хамгийн их зөрөөтэй гарсан асуулт энэ байлаа. Тоон судалгаан дээр хамгийн өндөр хувьтай гарч байсан хүмүүсийн орлогын тэгш бус байдал гэсэн шалтгааныг чанарын судалгаан дээр бараг дурдсангүй. Харьцангуй өндөр хувьтай гарч ирж байсан ажлын байрны эрэлт гэсэн хариулт чанарын судалгаан дээр огт дурдагдсангүй. Тэгэхээр чанарын судалгаанд оролцогсод энэ хариултуудыг авилгал үүсгэх эдийн засгийн хүчин зүйлд оруулж үзсэнгүй гэж үзэж болох талтай. Харин тоон судалгаан дээр харьцангуй бага хувьтай гарч байсан тендэрийн шударга бус өрсөлдөөнийг чанарын судалгааныхан нилээд түлхүү авч үзжээ. Тухайн үедээ эрх мэдэлтэй байгаа хүн өөртөө ашигтайгаар л асуудлыг шийдэж байна. Тендерийн хаалттай байдал, шударга бус өрсөлдөөн л авилгалыг бий болгож байна гэж хариулжээ. Тоон судалгаанаас нилээд ялгаатай либерал эдийн засаг нь өөрөө авилгалыг үүсгэж байна гэсэн хариулт ч гарч ирж байлаа. Тоон судалгаан дээр хүмүүсийн амжиргааны түвшинг дээшлүүлэх нь авилгалыг алга болгоно гэсэн хариулт илүү түлхүү харагдаж байсан бол чанарын судалгаанд амжиргааны түвшний өсөлт нь авилгалыг хориглогч хүчин зүйл болохгүй, учир нь орлогоосоо хамаарч хэрэглээ өндөр байдаг тул авилга үүнээс хамаарч өөрчлөгдөхгүй гэсэн хариулт нилээд гарч байлаа. Чанарын судалгаанд оролцогсод гадаадаас ирж байгаа зээл тусlamжийн хуваарилалт нь авилгалыг өөгшүүлж байгаа нэг чухал хүчин зүйл болж байна. Тэр зээл тусlamж нийгэм рүү биш эрх мэдэлтний халаас руу орж байна гэсэн байх юм.

Авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийг нийгэм хэрхэн үнэлж байгаа авч үзье. Тоон

### Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

судалгаанд оролцсон 493 хүний 60.4% нь хүмүүсийн ёс суртахууны үүрэг хариуцлага суларсан гэсэн хариулт өгсөн бол хүний мөс, нинжин сэтгэл алдартсан гэж 34.3%, хэтэрхий нэрэлхүү зангаас болж гэж 3.7%, хүний шунал ихдэж гар харах өвчтэй болсноос гэж 1.6% нь хариулжээ. Өмнөх асуулттай нэгэн адил энэ хариулт дээр тоон болон чанарын судалгаанд хамрагдагсад нилээд зөрүүтэй хариулж байна. Чанарын судалгаанд оролцогсод хүмүүсийн ёс суртахууны үүрэг хариуцлагын тоон судалгаан дээр хамгийн өндөр хувь авч байсан хариултыг нэг их гаргаж тавьсангүй. Харин ч хувийн хэвшлүүд эдийн засгийн хувьд хүчирхэг болоод ирвэл ёс суртахууны хүчин зүйл хамгийн сүүлд л нөлөөлнө гэсэн сонин хариулт өгч байв. Тэр ч байтугай өнөөгийн ийм нөхцөл байдал нь ямар ч ёс суртахууны хувьд цэвэр хүнийг сайндаа л турван жил л авилга авахгүй байлгана. Тэгээд л бусдын адил авилгалаа авдаг л болгоно шүү дээ гэжээ. Тэгэхээр чанарын судалгаанд оролцогсод хүний ёс суртахууны хүчин зүйл нь авилгалыг алга болгохгүй харин нийгмийн хүчин зүйл нь л илүү нөлөөтэй гэж үзжээ.

### Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

#### Дүгнэлт ба зөвлөмжүүд

Олон судалгааны дүнгээс болон энэ төслийн хүрээнд хийгдсэн хэд хэдэн судалгааны дүнгээс хараад Монголын нийгэмд газар авч, олон нийтийн санааг нилээд зовоож байгаа асуудал бол авилгалын асуудал гэдэг нь улам тодорхой болж байна. Ардчилал, чөлөөт зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотойгоор албан тушаалын байдал, төрийн өндөр алба хашиж байгаагаа ашиглан хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор бусдаас шан харамж авах явдал нилээд их гарах болжээ. Зах зээлд шилжих шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл, хууль хяналт шалгалтын систем дутагдалтай байсан нь авилгалын бодит байдлыг улам бүр ноцтой хэмжээнд хүртэл хурцдуулсан ба энэ нь жирийн ард иргэдийн хувьд үнэн шударгаар аж амьдралаа сайжруулах боломжийг улам бүр хааж, төрийн ард түмний төлөө үйлчлэх эрхэм үүргийг ганхуулахад хүрсэн юм.

Авилгалын байдлыг аль нэг нам, улс төрийн хүчнүүд дагнаж хөгжүүлээд байгаа бус, харин нийгэм, эдийн засгийн нилээд гүн гүнзгий учир шалтгаантай байгаа юм. Иймд энэ асуудлыг шийдвэрэд зөвхөн жирийн ард иргэд хүсэх нь хангалттай бус, төр засгийн оролцоо, улс төрийн өндөр албан тушаалтуудын сэтгэл, санаачлага, хариуцлага байж гэмээ нь шийдвэрэд асуудал болжээ.

Авилгалын асуудлыг цаг хугацааны хувьд авч үзвэл чөлөөт зах зээл хөгжиж, өмчийн олон хэлбэр бий болсон тэр үетэй л давхцаж байгааг энэ талаар гарсан олон судалгааны материалууд нотлож байна. Төслийн хүрээнд судалгааны багынхан авилгалын асуудлаар манай орнд хэвлэгдэж гарсан 130 гаруй ном зохиол,

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

судалгааны материалыудыг олж танилцах явцад эдгээр ажлууд нь 1990-ээд оны дунд үеэс л гарч эхэлсэн байх ба жил өнгөрөх тусам энэ талын материал улам их хэвлэгдэх болж янз бүрийн санхүүжилтээр судалгааны ажлууд ч их хийгдэх болжээ. Хэрэв энэ талын материалууд улам олширч, анхааруулга сануулга нь их болж байгааг өнгөн талаас нь авч үзээд дүгнэвэл энэхүү асуудал жилээс жилд харин улам хүчээ авч эрчимжиж байна гэж хэлж болох юм. Бид авилгалын байдал, түүнийг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийг авч үзэхдээ тоон болон чанарын судалгаандаа түшиглэн үнэлэлт тодорхой дүгнэлтүүдийг хийсэн болно.

Төслийн багийнхан 500 гаруй хүнийг хамарсан тоон судалгаа, 4 фокус группд хуваагдсан 32 хүн дээр чанарын судалгаа хийсэн. Бидний хийсэн энэ хоёр судалгаанд ч, бидний судалгаанаас өмнө, 1999 оноос эхлэн МНХХ, MYXAYT, Транспэренси Интернэйшнл байгууллага, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг зэрэг байгууллагуудын санхүүжилтээр хийгдсэн томоохон судалгаануудад ч оролцгосдын 94%-96.6% нь монголд авилгал газар авсан гэж үзсэн<sup>11</sup> нь өнөөгийн нийгэмд авилга хээл хахуулийн асуудал асар их болж нийгмийн гамшиг гэж хэлж болохуйц хэмжээнд хурснийг харуулж байна. Авилга хүмүүсийн амьдралын нэг хэсэг нь болж хувирсныг дээрхи асар өндөр хувь хэмжээ нотлон харуулж байна. Тэгэхээр өнөөдөр бидэнд авилгын асуудал хэр зэрэг түвшинд байна вэ гэж тогтоох биш харин яж газар сайгүй оршчихсон энэ үзэгдлийг арилгах вэ гэдэг л бодох

<sup>11</sup> MYXAYT, Авилгалын индекс: судалгааны тайлан, 2002, MYXAYT, Бизнесийн хүрээн дэх авилгал: судалгаа, 2000, НҮБХХ, Авилгалтай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт: харьцуулсан судалгаа, 2005, НҮБХХ, Авилгалын эсрэг хамтдаа: орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, 2006, ОУХА, Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ: эцсийн тайлан, 2005.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

асуудал болжээ. 2006 онд батлагдсан авилгалын эсрэг хуулийн хэрэгжилт амьдрал дээр тодорхой үр дунд хүрээгүй байна гэж үзэхээс өөр аргагүй.

Бидний судалгааны зорилго маань авилгалыг ямар албан тушаалтан, аль улс төрийн хүчин авч байна, авилгалын индекс ямар түвшинд байна гэх зэрэг өмнө өөр өөр байгууллагууд нилээд олон удаа хийсэн судалгааг дахин нотлох явдал биш байсан. Харин яж энэ авилгалыг арилгах вэ, түүнийг алга болгоход юу юу нөлөөлж болох вэ гэдэг дээр олон түмний санаа бодлыг гаргаж харуулахад голлон анхаарсан. Тиймээс бид иргэдийн өөрсдийн нь үйл байдалтай холбоотой, төрийн үйл ажиллагаагаа явуулах механизм, албан тушаалтнуудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн талын гэх мэт нөлөөлөх хүчин зүйлүүдийн талын асуултуудыг тавьж судалгаагаа явуулсан билээ.

Британийн судлаач Фрэнк Паркин өмч бол нийгмийн цөөнх хэсэг монопольчилж, эрх мэдэлдээ хүрэхэд ашигладаг социал саад гэж үзэж, энэ социал саадын тусламжтайгаар бүлгүүд нөөц баялагыг зөвхөн өөрөө хянах, бусдын боломжийг хязгаарлах гэж оролдог гэж үзэж байжээ. Харин Вебер социал саад бий болгоход өмчөөс гадна угсаатны хамаарал, хэл, шашин зэрэг статусын ялгааг ашиглаж болдог гэжээ. Өнөөгийн Монголын нийгэмд өмч, баялагын хуваарилалатанд ноёрхож байгаа бүлэглэлүүд эрх мэдлийг хуваарилан авах хандлага байгааг үгүйсгэх аргагүй. Ардчилал нь үүнийг хязгаарлан барих нэг нөхцөл болж байгаа боловч төдийлэн үр дунд хүрч чадахгүй байгаа юм. Тийм ч учраас авилгал, хээл хахуулийн асуудал нийгмийн хамгийн эмзэг асуудал болж, түүнийг шийдвэрлэх явдалд дорвitoй ахиц гарахгүй байна. Тийм учраас энэ бүлэглэлүүдийн зүгээс нийгмийн баялагыг шудрага бусаар

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Хянаад байгаа байдлыг өөрчлөх нь маш чухал алхам юм. Ийм өөрчлөлт хийхийн тулд авилгалын асуудалыг таслан зогсоох талаар амжилтанд хүрсэн бусад оруудын практик, туршлагыг судлах нь нэн шаардлагатай юм. Энэ асуудлыг тухайлбал авилгалын эсрэг олон улсын Транспаренси Интернейшнл байгууллагын судалгааны дүнтэй харьцуулан авч үзвэл сонирхолтой дүр зураг гарч ирэх болов уу.<sup>12</sup>

Судалгаанд хамрагдагсад авилгалыг таслан зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх гэсэн хүчин зүйлийг 90.3% нь маш их ач холбогдолтой, болон ач холбогдолтой гэж үзжээ. Энэ нь нийт ард иргэд авилгал гэдэг энэ гаж үзэгдлээс залхсан, түргэн салахыг эрмэлзсэн, өөрсдийнх нь амьдрал үйл ажиллагаанд үргэлж саад тогтор болж байгааг их мэдрэх болсонтой холбоотой юм. Түүнээс гадна авилгалын асуудлыг олон жил яриад л байсан тэр нь тодорхой үр дүнд хүрсэн нь харагдахгүй, байдал улам л дордож байгаагаас улбаатай болов уу. Иймээс өөрийн эрх ашгийг хамгаалахын тулд бүгдэд хатуу хариуцлага тооцох, авилга өгч авалцсан тохиолдолд хэнийг ч ялгалгүй шийтгэх, магадгүй өөрөө ч байсан ийм шийтгэл хүлээхээс татгалзахааргүй болжээ. Өөрөөр хэлбэл нийгэм бүхэлдээ Гоббсын хэлж байсанчлан “чи эрхээ шилжүүлбэл би ч гэсэн эрхээ шилжүүлнэ” гэж тохиороход бэлэн байгаа нь харагдаж байна. Энэ нь авилгал маш их болсон, түүнийг нийгэм ерөөсөө шийдэж чадахгүй байгааг л харуулах үзүүлэлт мөн.

Тэгэхээр үнэхээр хуулийн заалтыг чангатгах хэрэгтэй юу?

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

2006 он хүртэл мөрдэж байсан Авилгалын эсрэг хуульд хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргахаас зайлсхийсэн, буруу мэдээлсэн бол 5000-25000 төгрөгөөр тортогоно гэж заажээ. Энэхүү хуулийн заалт нь өнөөдөр засгийн газар, өндөр албан тушаалын халаа сэлгээ маш их хийгддэг болсон, янз бүрийн ашиг сонирхлын бүлгүүдийн өрсөлдөөн ширүүн болсон цаг үетэйгээ харьцуулж авч үзвэл үнэхээр зохицолдолгоо муутай байсан юм.

Тэгэхээр энэ хуулийн заалтыг өөрчилж торгуулийн хэмжээг өндөр болгоно гэж үзвэл хүн амын цалингийн түвшин доогуур байгаа үед хэт өндөр торгууль тавих нь ямарч нотолгоогүйгээр, шүүх шийдвэрлэхээс өмнө хүний эрхийг зөрчин шууд буруутгасан хэрэг болох бөгөөд юутай ч гэсэн хуулийн заалтыг хэт өндөр болгох нь эрх зүйн талаасаа боломжгүй. Өөрөөр хэлбэл хүнийг тодорхой хэмжээгээр авилга авч бай гэсэн санааг цухалзуулаад байгаа юм шиг, эсвэл шүүхээс өмнө авилгал авсан гэж тооцоод шийтгэж байгаа мэт болж байгаа юм. Харин 2006 онд батлагдсан Авилгалын эсрэг хуульд хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсвэл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болно гэсэн нь өмнөх хуулийн заалтаас илүү оновчтой шийдэл болсон гэж үзүүштэй байна.

Мөн дээрхи хуульд хээл хахуулийн болон авилгалын шинжтэй бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Ийм арга хэрэгслэл нь хир зэрэг үр дүнтэй байж чадах вэ. Олон нийт хуучин захиргаадалт, дарангуйлагч нийгмээ санагалзаад байгаа юм биш биз.

<sup>12</sup> Transparency International: the global coalition against corruption, available at <http://www.transparency.org/>

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Мэдээж хуулийн заалтыг цаг үетэйгээ тохируулж өөрчлөх нь гарцаагүй боловч хүний эрхийг дээдлэдэг нийгмийн байгуулалт маань олон түмний хүсээд байгаа шиг тийм хатуу заалт бүхий хуулийг гаргах бололцоо олгохгүй л болов уу. Хийсэн хэрэгтээ ял шийтгэл нь тохирсон байх гэдэг нь ардчилсан төрийн нэг зарчим шүү дээ.

Тэгэхээр бид яах хэрэгтэй вэ?

Үүнд хууль, хяналтын байгууллага үүргээ шударгаар биелүүлдэг байлагах талаар хамгийн их анхаарах ёстой байна. Авилаас сэргийлүүлж байх ёстой, хуулияа ягштал мөрдөж байх ёстой энэ байгууллагын үйл ажиллагаанд олон түмэн маш сэтгэл дундуур байдаг нь илт байна. Тоон судалгааны дүнгээс харахад авилгайд хамгийн их идэгдсэн байгууллагад эрүүл мэндийн байгууллага 42.8%, Гаалийн байгууллага, 37.1%, Боловсролын байгууллага 32.0%, Хууль сахиулах байгууллага 28.4%-иар эхний байруудыг эзэлж байсан юм (Зураг 3-ыг үз). Гэтэл чанарын судалгаанд оролцогсод авилгалыг яаж арилгах вэ гэдэг дээр санаалаа хэлэхдээ эрүүл мэндийн болон боловсролын байгууллага дахь авилгалын асуудлыг огт хөндөөгүй харин улс төрчид, төрийн өндөр албан тушаалтан, болон хууль хяналтын байгууллага дээр л тогтоод байгаа авилгалын сүлжээг хэрхэн арилгах вэ гэсэн арга замыг хайсан байх юм. Тэгэхээр багш нар, эмч нарт өгч байгаа чихэрийн цуглуулга, вино гэх мэт нь тооны хувьд гэхээр олонхи болчихдог мөртлөө чанарын хувьд, өөрөөр хэлбэл нийгэмд үзүүлэх хор хөнөөлийн талаас авч үзэхээр томоохон хэмжээний авилгалын сүлжээ нь төрийн өндөр албан тушаалтан хууль хяналтын байгууллага дээр байж, асар их хор хохирол үзүүлж байна гэж олон нийт үздэг юм болов уу гэсэн дүгнэлт хиймээр санагдана.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Томоохон авилгалыг жирийн нэг иргэд өгөх боломж байхгүй, харин дарс, чихэр гэх мэтийг бол дурын хүн гаргаад өгчихэж чадах билээ. Тэгэхээр ерөнхийдөө ард иргэдийн амжиргааны түвшин өндөрсөөд ирэхээр энэ жижиг хэмжээний бэлэг сэлтэн хахууль нь угаасаа утгаа алдах учраас энэ нь цагийн аясаар шийдэгдэх бизээ. Жишээлбэл АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй орны орлого сайтай хэн нэгэнд нэг набор, вино гэх мэтийг ажлаа бүтээлгэх гэж өгнө гэдэг нь утгагүй хэрэг гэж үзэж байна.

Гэхдээ энэ нь хүмүүсийг дараа дараагийн шатны авилгал өгч сургахад нөлөөлдөг учраас хүмүүсийн амжиргааны түвшинг сайжрахыг хүлээхгүйгээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байх ёстой болов уу. Харин томоохон авилгалын асуудлыг л хэрхэн шийдэх вэ гэдэг нь толгой өвтгөсөн асуудал юм.

Авилаас илрүүлэх ёстой байгууллага нь өөрөө авилгад идэгдсэн гэж 26.4%, албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсон гэж 25.6% нь үзэж байгаа нь нийт оролцогчдын 52.0% болж байгаа юм. Бидний судалгаан дээр та өөрөө авилгал өгөх тохиолдол гарч байсан байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд нийт оролцогчдын 28.4% нь хууль сахиулах байгууллагад гэж хариулсан байна. Гэвч энэ хариултанд заавал тооцож үзэх зүйл бол жирийн иргэн бүр хууль хяналтын байгууллагатай орооцолдоод байдаггүй, өөрөөр хэлбэл гэмт хэрэг ч гэх юм уу шүүх цагдаагаар явах шаардлага гараад байдаггүй явдал юм. Тэгэхээр 28.4% гэж байгаа нь энэ байгууллагад авилга бага байгааг хариулах бус харин ч энэ байгууллагаар ажил хөөцөлдөх хэрэгцээ гарсан хүмүүсийн тоотой харьцуулбал маш өндөр байж болох юм. Тэгэхээр энэ байгууллагыг өөрийг нь яаж цэвэрлэх вэ гэдэг нь өөрөө шийдэх ёстой асуудал санагдана.

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

Хэрэв энэ салбарт байдал сайжирвал нийгэмд авилгал алга болох хамгийн чухал нөхцөл бүрэлдэх юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж мөрдөхийг маш их болон их ач холбогдолтой гэж тоон судалгаанд оролцогчдын 84.0% нь үзэж байна. Тэгвэл чанарын судалгаанд оролцогчид үүнтэй адил бюрократуудын сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй гэсэн санаа цухалзуулж байна. Гэвч энэ нь нэг их давтагдахгүй байгаагаас харвал тэд үүнд нэг их ач холбогдол өгөхгүй л байгаа болов уу. Тэгэхээр хоёр судалгаагаа нэгтгэх гэж оролдвол мэдээж хэрэг төрийн албан хаагчдын хүний гар харсан сэтгэлгээг өөрчлөх ёстой. Гэхдээ энэ нь ямар нэгэн дүрэм журам гаргасанаар шийдэгдэх үү? Яаж хэрэгжих юм бэ? Энд чанарын судалгаанд оролцогчид төрийн албан хаагчидын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн санаа гаргаж байна. Гэтэл зарим нь цалинг нэмснээр асуудал шийдэгдэхгүй. Учир нь орлого нэмэгдэхийг дагаад тансаг хэрэглээ өсч байдаг тул энэ нь авилга авдаг байдлыг таслан зогсоож чадахгүй шүү дээ гэж байна. Гэхдээ бид авилгалын эсрэг боломжтой бүхий л аргаар тэмцэх хэрэгтэй байгаа тул бүх хүмүүсийг биш юмаа гэхэд нилээд хэсгийнх нь сэтгэлгээг өөрчлөх боломжтой учраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх тал дээр анхаарахаас өөр аргагүй.

Судалгаанд хамрагдагсад авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулж ажиллуулах гэсэн хүчин зүйлийг хэрхэн үнэлсэн талаар авч үзье. Тоон судалгаанд хамрагдагсадын 35.7% нь ийм байгууллагыг маш их, 35.9% нь их холбогдолтой гэж үзжээ. Хэдийгээр нийлбэр дүнгээрээ судалгаанд оролцогсодын дийлэнхи олонхи нь энэ байгууллагыг үнэлж байгаа мэт боловч тоон судалгаагаар нэрлэсэн авилгалыг хориглогч хүчин зүйлүүдээс

## Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс

хамгийн бага тоогоор “маш их” гэсэн үнэлгээ авсан байгаа юм (хүснэгт 7b, 7c, 7d, 7e – г тус тус харна уу).

Хүснэгт 7b, 7c, 7d, 7e энд орно

Мөн түүнчлэн чанарын судалгаанд оролцогчид хэрвээ ийм байгууллага байгуулахад хүрвэл иргэний төлөөлөл маягаар л зохион байгуулбал амжилтанд хүрнэ. Харин ямар нэг эрх мэдэл бүхий албан тушаалтан, субъектээс хамааралтай томилогдвол үйл ажиллагаагаа шударга явуулах боломж байхгүй, харин ч дахиад л нэг авилгал авдаг байгууллага нэгээр нэмэгдэнэ шүү дээ гэж үзэж байна. Тоон болон чанарын судалгаанд хамрагдагсадын санал дээр нэгтгэн шинжилж үзвэл олон түмэн үүнд төдийлөн их итгэхгүй байгаа харагдаж байгаа юм.

